

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний ажлын албаны талаар: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар аймгийн 2019 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай, Эвийн хүч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай, Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулж батлах тухай, Аймгийн мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл байгуулах тухай, Сүлд дуу, бэлгэдлийн загвар батлах тухай, Төрийн дээд шагналаар шагнуулахаар өргөн мэдүүлэх тухай зэрэг асуудлыг хэлэлцүүлэн нийт 10 тогтоол баталлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж сурталчлах ажлын хүрээнд аймгийн Прокурорын газартай хамтран Дуут, Эрдэнэбүрэн, Ховд, Буянт, Мянгад, Дөргөн сумдын иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, ЕБС-ийн 11-12 дугаар ангийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг танилцуулах, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2018 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2019 оны хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийж, гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг мэдээлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн талаар яриа таниулга хийж гарын авлага болон сэрэмжлүүлэг тарааж ажиллав.

Тайлант сард иргэд, байгууллагаас 9 өргөдөл хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэлээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, хяналт тавих, олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 27 дугаар тогтоолоор “Сумын ИТХ болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Буянт, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн Дөргөн, Чандмань, Дарви, Цэцэг, Мөст сумдад ажиллаж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Орон нутгийн өмчийн газар, Тогтвортой амьжиргаа-3 төсөл, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл оролцож байгаа бөгөөд дээрх сумдын ИТХ-ын үйл ажиллагааны явц, эрх зүйн бодлого, чиглэл, зорилтын хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах юм.

Аймгийн ИТХ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төлөөлөгчдийн өдөр” арга хэмжээг Цэргийн Гавьяаны Улаан тугийн одонт, Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцаж, ангийн захирагч хурандаа М.Болдбаатар Зэвсэгт хүчний болон батлан хамгаалах салбарын бодлого, 123 дугаар ангид зохион байгуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийг танилцуулж, цаашид аймгийн ИТХ-ын

Төлөөлөгчидтэй ангийн бие бүрэлдэхүүн хэрхэн хамтарч ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

Мөн “Ховд Номин шилтгээн” ХХК-ний шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, үйлдвэр болон үйлдвэрийн ажилчдад тулгамдаж буй асуудлуудыг талаар санал бодлоо солилцов.

Түүнчлэн Жаргалант суманд хэрэгжиж байгаа утаагүй зуух туршиж буй айл өрхүүдийн зуух, утаа, нүүрсний шаталт болон нүүрсний хэмнэлтийн талаар утаагүй зуух туршилтын үр дүнг хэлэлцэв.

Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 27 өргөдөл бичгээр хүлээн авч, 21 өргөдлийг шийдвэрлэж, 6 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 8 өргөдөл бичгээр хүлээн авч, 6 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа тус тус хүлээгдэж байгаа ба Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2 өргөдөл бичгээр хүлээн авч, 2 өргөдлийг уламжлаад байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 78,4 хувийн шийдвэрлэлттэй байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 2 сувгаар 14 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 12, биечлэн 2 санал хүсэлт ирүүлснээс гомдол 5, санал хүсэлт 8, шүүмжлэл 1 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 12 иргэний санал хүсэлтэд хариу өгч шийдвэрлэлт 85,7 хувьтай байна. Үүнд халаалтын асуудлаар 1, боловсролын асуудлаар 2, эрүүл мэндийн асуудлаар 2, орчны эрүүл ахуйн асуудлаар 3, бусад асуудлаар 6 иргэн тус тус хандсан.

Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандаж иргэдээс санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй болно.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 1 санал хүсэлт, 2 гомдол хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлэн хариу өгөв.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн Засаг даргын Тамгын газарт байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 707 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 2496 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр 3203 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 3 дугаар сард улсын төсвөөс авах санхүүжилт 4231,7 сая төгрөг бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардал, ОНХС-ийн зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 2478,9 сая төгрөг, аймгийн хөрөнгө оруулалт, сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудад 4629,3 сая төгрөг, халамжийн санд 35,0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 5926,6 сая төгрөг, цэцэрлэг 2477,9 сая төгрөг, хүн эмнэлэг 1372,2 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт

100,6 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 73,6 сая төгрөг тус тус санхүүжүүлээ.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр, авлагыг нэгтгэн гаргаж, Сангийн яаманд хүргүүлэн нийтэд мэдээлж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/129 дугаар захирамжаар сумдын санхүүгийн албаны бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулж, төсөвт байгууллагуудад нягтлан бодогч, Жаргалант сумын зарим цэцэрлэгт няравын орон тоо шинээр ажиллуулах тухай баталсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хэлтсийн даргын 5/493 дугаар албан бичгээр 10 заалт бүхий арга хэмжээний жагсаалтыг сумдын Засаг дарга, Төсвийн шууд захирагч нарт хүргүүлэн ажиллаж байна.

Нийт төсөв захирагчдын 2019 оны цалингийн санд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн 17 сумдын Санхүүгийн алба, Багийн Иргэдийн Нийтийн хурал, Багийн Засаг дарга нарт “Орон нутгийн хөгжлийн сангийн гарын авлагын 1, 2 дугаар бүлгүүд буюу ОНХС-г төлөвлөх болон төсөл арга хэмжээг эрэмбэлэх нь” сургалт зохион байгуулж тус сургалтаар нийт 180 хүнийг хамруулж чадавхжууллаа. “Тод санхүү” нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө үзүүлэх төвийн 2 сургагч багш сум, байгууллагуудын нягтлан бодогч нарт нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах арга зүйн чиглэлээр сургалт хийж 80 гаруй хүн хамрагдлаа.

Боловсрол, соёл, шинэжлэх ухаан спортын Сайд, Эрүүл мэндийн сайдын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах чиглэлийн дагуу сум, байгууллагуудын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан аймгийн Засаг даргын 2019 оны А/186 дугаар захирамжаар батлан санхүүжилтийг хуваарийн дагуу олгож байна.

Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газарт 2/638 дугаар албан бичгээр төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн нарын одоо ашиглаж байгаа болон шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг маягтын дагуу гаргаж хүргүүлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг тооцож, биелэлтийг маягтын дагуу гарган хэлтсийн даргаар хянуулан албажуулж хүргүүлээ. “Төсвийн төлөвлөлт, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөө” сэдэвт сургалтад төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн хамрагдав.

Нягтлан бодогчдод санхүүгийн тайланг хуулийн хугацаанд боловсруулан Э-тайланд шивүүлэхэд анхаарч, зөвлөгөө өгч ажилласнаар тайлангийн шивэлт 80 хувийн гүйцэтгэлтэй байна. 2018 оны жилийн эцсийн тайлан тушаасан 66 нягтлан бодогчдын ажлыг батлагдсан үзүүлэлтээр дүгнэв.

Аж ахуйн нэгжийн 2018 оны жилийн эцсийн тайлан гаргах 1756 байгууллагаас 1606 тайланг хүлээн авч, баталгаажуулсан нь 91,4 хувийн хамрагдалтай байгаа нь өмнөх оноос 235 тайлан илүү буюу 16,8 хувиар өссөн байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 3665 ширхэг зардлын ваучер бичиж, 19961,0 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн төдийгүй 1562 аж ахуйн нэгж, хувь хүний мэдээллийг засварлаж, шинээр орууллаа. Шилэн дансны

тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “теле маркетинг” үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогч 300 гаруй хүнд мессежээр чиглэл өгч сар бүр үр дүнг дүгнэн ажиллаж байна.

Татварын хэлтэс тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн улсын бүртгэл, статистикийн газартай тулгалт хийж Тахаст болон Trips програмд бүртгэл хийж ажиллалаа. Үүнд: ХХК 21, төсөвт байгууллага 2, ТББ-7, нийт 31 аж ахуйн нэгж байгууллага бүртгэсэн.

Төрийн сангийн цахим сайтаар дамжуулан татварын орлогын хуулгуудыг өдөр бүр нэр төрлөөр авч татварын мэдээллийн санд боловсруулалт хийлээ. Мөн татварын данс андуур ч орсон 12 татвар төлөгчтэй холбоотой 11 төрлийн татварын 15.0 сая төгрөгийг залруулах бичилт хийсэн.

Хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулах, бүхий л эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвших, хөндлөнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг хангаж ажилласнаар 35 ширхэг 317.8 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулав.

2019 оны 03 дугаар сарын 28-ны байдлаар улс, аймаг, сум орон нутгийн төсөвт нийт 3208.9 сая төгрөг оруулахаас 2359.5 сая төгрөг орж татварын орлогын бүрдүүлэлт 73.5 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 577.5 сая төгрөг оруулахаас 481.0 сая төгрөг орж 83.3 хувийн, аймгийн төсөвт 2153.0 сая төгрөг оруулахаас 1492.0 сая төгрөг орж 69.3 хувийн, сум орон нутгийн төсөвт 478.4 сая төгрөг оруулахаас 386.4 сая төгрөг орж 80.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Татварын Хяналт шалгалтанд 14 татвар төлөгчийг хамруулж, шалгасан татвар төлөгч бүрт гаалийн мэдээлэл болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 204.3 сая төгрөгийн зөрчилд 20.1 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 9.5 сая төгрөгийн торгууль, 5.1 сая төгрөгийн алданги, нийт 34.7 сая төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдуулсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 12 зүйлийн 12.1.6 дахь заалт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 31-р зүйлийн 31.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д заасны дагуу 2019 оны 1 сарын 02-ны өдрөөс эхлэн Сангийн сайдын удирдамжаар Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сангуудын 2017, 2018 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнгийн байдалд хяналт шалгалт хийв.

Эрүүл мэндийн даатгалын санд 2018 онд аж ахуйн нэгжид ажилладаг даатгуулагчийн шимтгэлд 3,371.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,149.1 сая төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн даатгалын шимтгэлд 403.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 443.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг 116 хувиар давуулан биелүүллээ. Мөн халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд 75,5 сая төгрөгийн зөрчил илэрсэний 2,5 сая төгрөгийг улсын байцаагчийн актаар төлүүлэхээр, 73,0 сая төгрөгийг хугацаатай үүрэг өгч албан шаардлагаар арилгуулахаар чиглэл өгөв.

Нийт 2 байгууллагын 4 санд хийсэн шалгалтаар 136,8 сая төгрөгийн зөрчил илэрсэнээс улсын байцаагчийн актаар 3,9 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төлүүлэхээр, 2,1 сая төгрөгийг сангийн данснаас нөхөн олгуулахаар, 2,5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төлүүлэхээр, 128,4 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллав.

Аймгийн Статистикийн хэлтэс нь тайлант сард 1034 аж ахуйн нэгж байгууллагын жилийн эцсийн тайланг хугацаанд нь бүрэн хамруулж Үндэсний статистикийн хороонд дамжууллаа.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Булган сумын Бүрэнхайрхан, Үенч сумын Хөх-Үзүүр, Жаргалант сумын Магсаржав, ажиллах хүчний судалгааг Мөст сумын Улаантолгой, Мянгад сумын Баянхошуу, Дөргөн сумын Өгөөмөр, Жаргалант сумын Магсаржав багын нийт 66 өрхөөс авч, мэдээллийг шивж байна.

Улсын хэмжээнд 4 жилд нэг удаа хийгддэг “Цаг ашиглалтын судалгааны тоологч, ахлагч нарыг бэлтгэх” сургалт манай аймагт зохион байгуулагдаж, сургалтанд Үндэсний Статистикийн хорооны 2 сургагч багшаар ажиллаж, сургалтанд Говь-Алтай, Ховд аймгуудын статистикийн хэлтсийн дарга нар, судлаач, мэргэжилтнүүд нийт 14 хүн хамрагдлаа. Цаг ашиглалтын судалгаанд Жаргалант сумын Баатархайрхан, Эрдэнэбүрэн сумын Шураг, Мөнххайрхан сумын Борт, Булган сумын Баянсудал, Бүрэнхайрхан багийн нийт 40 өрх хамрагдаж, мэдээллийг хянах, кодлох ажил хийгдэж байна.

Аймгийн нийгэм эдийн засгийн 2 дугаар сарын танилцуулгыг бэлтгэж ЗДТГ-ын хэлтэс агентлагын дарга нарт мэдээлж, веб сайтад байршуулав.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд 3 дугаар сарын 22-оос Төрийн байгууллагын бүртгэл, ХАӨМС-ийн бүртгэлийг сайжруулах, мэдээллийг баяжуулах 14 хоногийн болон сарын аяны үйл ажиллагааг эхлүүлж, 91 багийн Засаг дарга, тооллогод ажиллах түр товчоодод холбогдох мэдээллийг өгөөд байна.

Дөрөв: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хууль эрх зүйн хэлтсийн хурлыг 7 хоног бүр зохион байгуулж хийх ажлуудаа төлөвлөн ажиллалаа. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан бэлтгээд байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд хэрэгжих “Эрх зүйн боловсролыг иргэн бүрт” аян өрнүүлэхээр удирдамж боловсруулан батлуулаад байна..

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газраас ирүүлсэн зөвлөмж чиглэлийн дагуу “Ухаалаг, аюулгүй хэрэглээ” сэдэвт өдөрлөгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Булган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Зоонозын өвчин судлалын төвийн даргын гаргасан 2018 оны тушаалуудыг хянаж хууль зүйн дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн.

Шүүхээс нотлох баримтын шаардлага хангуулан ирүүлэхийг хүссэн Монгол улсын Ерөнхий сайдын 2018 оны 157 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2018 оны Б/25, Б/49 дүгээр захирамжуудыг лавлагааны сан болон хадгаламжийн нэгжээс хуулбарлан нотариатаар гэрчлүүлэн шүүхэд хүргүүлээ.

Цагдаагийн газар: Тус газраас тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Хурд”, “Тусгай дуут дохио ба гэрэл дохио”, гэмт хэрэгтэй тэмцэх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй эрүүгийн хэргийг илрүүлэх, хүчиндэх гэмт хэргийг илрүүлэх зэрэг чиглэлээр “Нуугдмал”, “Залилах гэмт хэргийн шийдвэрлэлт 2019”, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нэг хором” нэгдсэн арга хэмжээ, тус газраас “Шийдвэрлэлт 2019”, “РС цахим тоглоом-хяналт, шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 мэдэгдэл бичиж, 3 мэдэгдлийн хариуг авч, 1 аж ахуйн нэгжийн биелэлтийг газар дээр нь шалган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран Жаргалант сумын хөгжлийн бэрхшээлтэй 34 иргэнд эрх зүйн сургалт гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгууллаа.

Гадаадын иргэн харъяатын Баруун бүсийн газрын ажилтнуудад, мөн Үенч, Булган сумдын 200 гаруй иргэнд хар тамхи мансууруулах бодис, хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, 210 ширхэг гарын авлага тараав.

Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн 120 ажилтан, алба хаагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, жендерийн тэгш байдал, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хуулиар 1 өдрийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, 120 ширхэг гарын авлага тараалаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ховд” телевизтэй хамтран теле хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулж, иргэд олон нийтэд хүргэсэн.

Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж албан байгууллагуудад 6 удаагийн сургалтаар 184 иргэнд мэдээлэл өгч ажиллав.

Дүрэмд нэмэлтээр орсон “Сургууль орчмын бүс”-д бий болгох шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээний судалгааг гаргаж, Жаргалант сумын ЗДТГ-т хүргүүлээ. Хүүхдийг зам

тээврийн осол, гэмт хэргээс урдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдад замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох талаар яриа таниулга хийв.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар багш, эцэг эхчүүдэд 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар 3 удаа яриа, таниулга хийсэн.

Бага ангийн сурагчдад зориулсан замын хөдөлгөөний дүрмийн хүүхэдтэй холбоотой заалтуудаар бэлтгэсэн 120 ширхэг зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлгийг бэлтгэн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулиудад тараав.

Манхан сумын нутаг дэвсгэрт байрлах хяналтын постонд 2 алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэж, дамжин өнгөрсөн тээврийн хэрэгсэл бүрийн бичиг баримт ачаа тээшинд үзлэг шалгалт хийж ажилласан.

Объект, субъектын цахим судалгааны ажлын хүрээнд орон гэргүй тэнэмэл 19 иргэдийг судалгаанд хамруулж, багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай хамтран гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж, хоноглодог орон сууцны орц, хонгилыг эргүүлийн чиглэлд хамруулан үзлэг шалгалтыг зохион байгууллаа.

Орон нутгийн 4 телевизтэй хамтран ажиллаж, аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, уралдаан тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, бусад арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд тухай бүр мэдээлэл, сурвалжлага хүргэж ажиллав.

“Теле камерын хяналтын нэгдсэн төв” нь камерын хяналтаар 24 зөрчил илрүүлж, 3 зөрчил гаргасан иргэнд нийт 60,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж, таксинд гар утас, эд зүйлээ мартсан гэх 9 иргэний хүсэлтийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажиллав.

Аймгийн хэмжээнд 3 дугаар сарын 25-ны байдлаар нийт 34 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3, хулгайлах гэмт хэрэг 12, мал хулгайлах гэмт хэрэг 3, залилах гэмт хэрэг 1, алдаатай гүйлгээ андуурсан илгээмж завших 1, хууль сахиулагчийг эсэргүүцэх 1, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 1, завших 1, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 1, нийгмийн даатгалын шимтгэл төлхөөс зайлсхийх 1, авто тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдсэн.

Тус газарт тайлант сард иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 260 гомдол мэдээлэл хүлээн авсны 62 буюу 23,9 хувийг гэмт хэргийн шинжтэй, 198 буюу 76,1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл ирсэн. Гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: авто тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 6, бусад 164, бусдын биед халдах 2, цахим доромжлох, гүтгэх 1, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 5, зам тээврийн осол/хүн нас барсан, эд материалын хохирол учирсан/ 5, СТХЖ 1, мал хулгайлах 9, ОНАТБА 14, завших 1, худалдаа

үйлчилгээний журам зөрчсөн 2, хулгайлах 19, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3, хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 16, хууль сахиулагчийг эсэргүүцэх 6, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 5, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг 1 гомдол мэдээлэл тус тус хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ. Тус газар тайлант сард зөрчил гаргасан 108 хүнийг саатуулж, 132 хүнийг 15,256,500 мянган төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 80 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодсон эрхийг хасаж, 23 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж ажилласан болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Тус анги нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ангийн хэвийн үйл ажиллагаа, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр төлөвлөгөөний дагуу ажиллав.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилч, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж ирсэний зэрэгцээ 7 хоногийн мягмар гарагт ангийн нийт бүрэлдэхүүнд хичээл, сургалт, мэдээлэл хийж, жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна.

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн Мягмар гарагт сургалт зохион байгуулж, алба хаагчдын дэвтэр хөтлөлтийг жигдлэн нууцын дардасаар баталгаажууллаа. Сургалтад хамрагдах алба хаагчдын ирц оролцоонд газрын дарга биечлэн хяналт тавьж ажиллалаа.

Ангийн “Ёс зүйн салбар хороо”-оос Төрийн албаны болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандартыг сахин хангуулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэж хагас бүтэн жилээр албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт болгон дүгнэсэн.

Хорих ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд ангийн даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний алба: Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын тушаал, албан даалгавар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2019 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, цаашид хэрэгжүүлэх саналыг биелүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Алба хаагчдад 7 хоногийн 5 дахь өдөр бүр өглөөний мэдээлэл хийж, англи хэлний ахисан шатны дамжаанд алба хаагч нарыг бүрэн хамруулж 54 цагийн сургалт ороод байна. Шүүхийн шинжилгээний албанд хандаж 16 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж 70 ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 15 бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүллээ.

2018-2019 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 1 цагийн сургалт зохион байгуулсан. Ховд Их сургуулийн гадаад хэлний танхимийн англи хэлний “Ахисан” түвшиний мэдлэг, чадвар эзэмшүүлэх 64 цагийн сургалтанд алба хаагч нарыг хамруулж хэлний түвшинг нь дээшлүүлэхэд удирдлагаас анхаарч ажиллалаа.

Албаны 2018 оны түр хадгалах 42 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1 хадгаламжийн нэгж, байнга хадгалах 12 хадгаламжийн нэгж нийт 55 хадгаламжийн нэгжпau архив зүйн шаардлагын дагуу эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын архивт байршуулсан. Санхүүгийн 2009-2017 оны баримтуудыг нөхөн бүрдүүлж байнга хадгалах 36 хадгаламжийн нэгж үүсгэн бүртгэлжүүллээ.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим khovdnifs@yahoo.gov хаягаар авч байгаа 1 дүгээр улирлын хувиарт мэдээ, тайлан, биелэлтүүдийг гаргаж Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн холбогдох газар, хэлтэст хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан Спортын олон төрөлт тэмцээн, аймгийн Засаг даргын нэрэмжит Марш тактикийн тэмцээнд баг бэлтгэж амжилттай оролцов.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 4 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 40, эд эсийн шинжилгээ 4, хавтаст хэрэг 1, химийн 7, биологийн 7, криминалистикийн 2 шинжилгээг хийж, дүгнэлт гаргаж, үүрэгт ажлаа гүйцэтгэв.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 13 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 5 ширхэг мөр, гутлын мөр 11, тээврийн хэрэгслийн мөр 2, бичил мөр 1, бусад ул мөр, эд мөрийн баримт 6-г илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 53, 3 гарын мөр авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн шинжилгээ, химийн шинжилгээ, биологийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүд болон ирүүлсэн тогтоолуудыг тухай бүрт нь цахим санд шивж ажиллав.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тус хэлтэс нь тайлант сард нийт 2527 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас иргэний бүртгэлийн чиглэлээр 1653, Үүнээс: аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 104, шилжин ирсэн иргэд 19, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 85, гадаад паспорт олголт 250, иргэний үнэмлэх шинээр олгосон 154, сунгалт 231, дахин олгосон 141, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэл 337 Үүнээс: төрөлт 197, үрчлэлт 5, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 17, эцэг тогтоолт 8, гэрлэлт 37, гэрлэлт дуусгавар

болсны бүртгэл 1, нас барсны бүртгэл 38, нөхөн бүртгэл 30, регистр олголт 4, иргэний бүртгэлийн лавлагаа олголт 436, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 728, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 136 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Иргэдээс нийт 10 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 4 иргэний өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 иргэний өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлж, 4 өргөдлийн шийдвэрлэлт хүлээгдэж байна.

Тав : Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Монгол Улсын засгийн газар, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдлага болгон Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

“Сургууль завсардсан хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад орон нутгийн удирдлагын үүрэг оролцоо” сэдэвт сургалтад ЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХҮГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, сумдын Засаг даргын Тамгын газар, НТБТ, ЕБС-ийн улирлдлага, багш нар нийт 55 хүн оролцож, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих арга зүйд суралцлаа.

“Хүүхдэд ээлтэй орон зай” сэдэвт сургалтыг МУБИС-ийн багш Ph.D Д.Одгэрэл, Насан туршийн боловсролын үндэсний төвийн мэргэжилтэн зөвлөх багш С.Ундрал нар зохион байгуулан, сургалтад аймгийн НТБТ, 3 дугаар сургуулийн багш нар хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцаж, НТБТ, 3 дугаар сургуульд хөгжлийн төв байгууллаа.

Олон улсын нийгмийн ажилтны өдрийг тохиолдуулан Жаргалант сум, аймгийн ЗДТГ хамтран зохион байгуулсан нийгмийн ажилтны сургалтад аймгийн төвийн 7 сургуулийн нийгмийн ажилтан, БСУГ-ын мэргэжилтэн нар оролцлоо.

Бүрэн дунд боловсролын биологийн хичээлийн хүнд агуулга, олимпиадын бодлого онолын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын биологийн 28 багшид МУИС-ийн Ph.D, дэд проф багш Г.Баярмаа сургалт зохион байгуулж чадавхжууллаа.

Дэлхийн Зөн Олон улсын байгууллагад “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь” сэдэвт сургалтын төсөл бичиж Жаргалант, Мянгад, Манхан, Зэрэг, Дөргөн сумдад сургалт зохион байгуулахаар төлөвлөн, Жаргалант сумын цэцэрлэгүүдийн сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

БСУГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/10 тоот тушаалаар батлагдсан ЕБС-ийн багш, сурагчдын мэргэжлийн хичээлийн олимпиад зохион байгуулах журмын дагуу аймгийн ЕБС-ийн багш, сурагчдын мэдлэг, оюуны сорил болсон мэргэжлийн хичээлийн олимпиадын II давааг 3 дугаар сарын 2-оос 4 дүгээр

сарын 8-ны өдрүүдэд төвийн 1, 3, Цаст-Алтай сургуулиудад зохион байгуулахаар төлөвлөсний дагуу олимпиадууд эхлээд байна.

Сурагчдад зураг зүй, дүрслэх геометр, дизайны төрлийн хичээлээр зохион бүтээх, техник сэтгэлгээ, орон зай, гоо сайхны мэдрэмж, сэтгэн бодох үйлийг төлөвшүүлэх, багаар ажиллах чадварыг дэмжих, багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, харилцан туршлага солилцох зорилгоор МУБИС-тай хамтран дизайн, зураг зүйн хичээлийн олимпиадыг амжилттай зохион байгууллаа.

Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуулийн нэрэмжит монгол хэлний хичээлийн “Эх хэл эрдмийн түлхүүр” уралдаанд 5 дугаар ангийн 64 бүлгийн 1667 сурагч оролцож, 99 хувийн ирцтэй, гүйцэтгэлийн дундаж 44 хувьтай шалгагдлаа.

БСУГ-аас цэцэрлэг, сургууль, соёлын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөн туслах, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах, сумын удирдлагуудтай хамтран ажиллах, БСШУСЯ-ны баримтлах бодлогыг сурталчлах, боловсрол, соёлын салбарт олон нийтийн оролцоог өргөжүүлэх зорилгоор Дуут, Мөст, Мөнххайрхан, Мянгад, Буянт суманд ажиллалаа. Хяналт үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлын хүрээнд 16 багшийн цагийн судлагдахуун, цагийн сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ажиглалт хийж, сургалтын арга зүй, технологийг сайжруулах 7 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Ажиллах явцад 600 гаруй сурагч, 80 багшаас мэдлэгийн шалгалт авч, эцэг эх, 90 багш ажилтан, 120 сурагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч, багш, удирдлага, ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Багш ажлын талбарт хөгжих хамтын үйл ажиллагаанд суурилсан хөгжлийг дэмжих, багшлах арга зүйн туршлагаа түгээх, суралцах зорилгоор “Судалгаанд суурилсан хичээлийг судалья” хичээлийн судалгааг 2, 3 дугаар сургуулиудад 2 удаа зохион байгуулж, 12 судлагдахуунаар 386 багш хэлэлцүүлэгт оролцлоо.

Ерөнхий боловсролын 12 дугаар анги төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, урьдчилсан байдлаар түвшин тогтоох, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, урлагийн газраас ЭЕШ-ын өмнөх их сорилго шалгалтыг математик, монгол хэл, хими, биологи, физик, нийгмийн ухаан, англи хэлний хичээлээр зохион байгуулж нийт 1196 сурагч хамрагдлаа.

Үнэлгээний төвийн чанарын үнэлгээний судалгаанд түүврээр Булган 1 дүгээр сургууль, 2 дугаар сургууль, Зэрэг сумын сургууль сонгогдсон. Энэхүү үнэлгээний шалгалтад 3, 9, 10 дугаар ангийн сурагчид монгол хэл, математик, газарзүй, физик, хөгжим, хүн орчин хичээлээр судалгаанд хамрагдлаа.

Жаргалант сумын 12 хувийн цэцэрлэгийн хүүхдийн тоо, хүүхэд харах үйлчилгээний 12 газрын үйл ажиллагаатай танилцаж, хүүхдийн ирц бүртгэлд хяналт тавьж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүээр зүйлийн 24,2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 184 дүгээр тогтоолын 3 дугаар

хавсралтаар баталсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/648 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/756 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсэг томилогдон сумдын соёлын төвийн орон нутаг судлах танхимын сан хөмрөгийн тооллогыг 2019 оны 2 дугаар сарын 18-наас 3 дугаар сарын 17-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

STEM хөтөлбөрийн ашиглалтын болон хэрэгцээний судалгаа гаргаж БСШУСЯаманд, сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 дүгээр шатны сургалтын тайлан, 4 дүгээр шатанд өрсөлдөх 24 сургуулийн 62 төслийг Боловсролын чанарын шинэчлэл төсөлд хүргүүллээ.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтан, ажиллагсад, хүүхэд багачуудад байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, зөв хандлагыг төлөвшүүлэх, сурагчдын танхимын сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадварыг амьдралд хэрэгжүүлж, зөв амьдрах арга ухаанд сургах, санаачилгыг дэмжих, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх ойлголтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сургууль, цэцэрлэг болон орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон нутаг дахь манлайллыг бий болгох ая тухтай, цэвэр цэмцгэр,эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “хоггүй орчин-Ногоон ирээдүй” сэдэвт бүтээлч аяны удирдамжийг 32 цэцэрлэг, 25 сургуулиудад хүргүүлэн аргазүй зөвлөмжөөр чиглүүлэн ажиллаж байна.

“Чадварлаг багш” боловсролын салбарын аварга шалгаруулах тэмцээний удирдамжийг боловсруулан батлуулж, сургууль цэцэрлэгүүдэд хүргүүлж, “Жангар” дуулалт жүжигт хяналт хийлээ.

Япон улсын Хүүхдийг ивээх сангийн Боловсролын төслөөс хэрэгжүүлж буй боловсролд хүүхдийг тэгш хамруулах төслийн хүрээнд аймгийн хэмжээний 6-18 насны хүүхдийн судалгааг гаргаж сургуульд болон насан туршийн боловсрол төвөөр суралцуулах сургуулийн гадна байгаа хүүхдийн илрүүлэг судалгаагаар сургуульд болон албан бус боловсролоор боловсрол эзэмшиж байгаа 19421 суралцагч, аймгийн статистикийн хэлтсээс гаргаж ирүүлсэн 6-18 насны 22347 хүүхдүүдээс суралцахгүй байгаа суралцагчийн мэдээллийг улсын хэмжээний БСМС-ээс хайлт хийж тодруулсан мэдээллийг Жаргалант сумын насан туршийн боловсрол төв болон багийн Засаг дарга нарт хүлээлгэн өглөө. Энэхүү төсөл нь Жаргалант сумын Хайрхан, Бугат, Буянт, Бичигт, Наран багт хэрэгжиж байгаа юм.

Сургууль, цэцэрлэгүүд 2018 оны төсвийн орлого зарлага гүйцэтгэлийн тайлан БДБ-17, БДБ-17А, хөрөнгийн тайлан БДБ-17.1, БДБ-17.1А тайлан, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд 2018 оны төсвийн орлого зарлага гүйцэтгэлийн тайлан СӨБ08Б, хөрөнгийн тайлан СӨБ09Б-г системд оруулсныг татан авч, хяналт хийж, зөрүүтэй оруулсан байгууллагын мэдээллийг дахин хянуулж, зөрүүг арилган аймгийн мэдээг баталгаажууллаа.

2018-2019 оны хичээлийн жилд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд олгох боловсролын баримт бичгийн захиалгыг сургууль, насан туршийн боловсрол

төвөөс сурагчдын дэлгэрэнгүй мэдээллийн хамт хүлээн авч нэгтгэж суурь боловсрол эзэмшиж төгсөх 1604 гэрчилгээ, бүрэн дунд боловсрол эзэмшиж төгсөх 923 үнэмлэхний захиалгыг БСШУСЯ-нд хүргүүлээд байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж байгаа хэвлэмэл материалын нэр төрлийг тодорхойлох зорилгоор боловсролын хүрээлэнгээс 1-12 дугаар ангид сурах бичгээс гадна хэрэглэж байгаа нэмэлт хэрэглэгдэхүүн болох гарын авлага, сургалтын материал, дасгал ажлын ном, бодлогын хураамж зэргийн талаар мэдээлэл цуглуулахаар сонгогдсон 1, 3, 6, 7, Мөст сумын мэдээллийг маягтын дагуу нэгтгэн хүргүүлээ.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 2016-2018 оны хэрэгжилтийн тайлан гаргахтай холбоотой 2016-2018 онд хөдөө орон нутагт өөрийн хүсэлтээр ажиллаж байгаа багшийн тоо, тухайн багшийг ажиллахад хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангагдсан багшийн тоо, олгосон урамшууллын хэмжээ бүхий судалгааг гаргаж холбогдох байгууллагад нэгтгэн хүргүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр: Тайлант сард “Инээмсэглэл-Эерэг хандлага-Эх, хүүхэд бидний ирээдүй” сэдэвт Эрүүл мэндийн салбарын аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, Face to Face буюу нүүр тулсан ярилцлага, удирдлагуудтай 2018 оны ажлын ололт, амжилт цаашид анхаарах асуудлыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өглөө.

Зөвлөгөөнд Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн тусламжийн газрын дарга, аймгийн удирдлагууд оролцож, улс, аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын хэмжээнд баримталж буй бодлого, дэвшүүлсэн зорилтын талаарх илтгэлүүдийг хэлэлцүүлж, “Инээмсэглэл-Эерэг хандлага-Эх, хүүхэд бидний ирээдүй” уриаг дэвшүүлэн эрүүл мэндийн ажилтан бүр өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, ёс зүй, харилцаа хандлагаа сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулахад анхаарч ажиллахыг зөвлөв.

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд өвчнөөс урьдчилан сэргийлэх, чиглэлээр Осол гэмтлээс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд “Осол гэмтлээс сэргийлэх аюулгүй орчныг бүрдүүлж анхаарал болгоомжтой алхацгаая” сэдвийн дор 3 сарын аяныг эхний улиралд зохион байгуулж анхан шатны нэгж, байгууллагуудын хэмжээнд 70 удаагийн сургалтаар 2300 иргэдэд мэдлэг, хандлагыг өөрчлөх арга хэмжээг зохион байгуулж, 7500 иргэдэд 12000 гаруй сурталчилгааны материалыг түгээж сурталчлан, өсвөр насны эрт илрүүлэг үзлэг, сургалт сурталчилгааг Хөгжил политехникийн коллежийн оюутнуудад хүргэж, 310 оюутныг Бэлгийн замын дамжих халдварын үзлэг шинжилгээнд хамрууллаа.

Иргэдэд сүрьеэ өвчний талаарх ойлголтыг хүргэж түгээх, тэднийг үнэн бодит мэдээллээр хангахад анхаарч нийтийн үйлчилгээний газруудаар сүрьеэ өвчний сурталчилгааг 200 гаруй иргэдэд сурталчлан гарын авлага материал түгээлээ.

Анхан шатны лабораторын оношилгооны чадавхийг бэхжүүлэх, лаборантуудыг чадавхжуулах зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторын тасагтай хамтран сум, өрхийн лаборант нарын сургалтыг зохион байгууллаа.

“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 9 шүдний эмнэлгийн үйл ажиллагаанд сонгон шалгаруулалт зохион байгуулж, 2-12 насны хүүхдийн шүдний өвчний тархалтын судалгааг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс гаргуулж нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүллээ. Аймгийн хэмжээнд 2-12 насны хүүхдийн өвчлөлийн тархалт дунджаар 72.3 хувьтай байна.

Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай хамтран ажиллах гурвалсан гэрээний биелэлтийг дүгнэж хэлэлцүүлэн, 2019 гэрээг байгуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дэлхийн эмч нарын өдрийг угтсан арга хэмжээг зохион байгуулах удирдамж боловсруулан батлуулж эрүүл мэндийн байгууллагуудад албан тоотоор хүргүүллээ. Дэлхийн их эмч нарын өдрийн угтан “Эмч судлаач” онол практикийн хурал зохион байгуулж, салбарын болон мэргэжлийн холбогдолтой 19 илтгэл тавигдаж тэргүүн илтгэл мэдээллийг шалгаруулж шагнаж урамшууллаа.

Халдварт өвчнөөс сэргийлэх зорилтын хүрээнд “Улаан бурхан өвчний урьдчилан сэргийлэлт хариу арга хэмжээ” цахим сургалтанд холбогдох мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг оролцуулж мэдээллээр хангаж, сумын эрүүл мэндийн төвүүдэд албан тоот хүргүүлэн мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч, пневмококкийн болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг 4 сараас нэвтрүүлэхтэй холбогдуулан Халдварт өвчин судлалын 2 мэргэжилтнийг урьж “Пневмококк болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 94 ажилтныг хамруулан сургалт, арга зүйн зөвлөмж зааврыг өгч ажиллалаа.

Халдварт өвчний 3 сарын тандалтын мэдээллээр салхинцэцэг өвчний 11 тохиолдол, гар хөл амны өвчин 1, тууралтад халдварт өвчин 1 тус тус бүртгэгдсэнийг ewar програмаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалтын албанд мэдээллээ.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв хамтран хэрэгжүүлж буй “Тарилгатай халдварт өвчний дархлал тогтоц, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа”-г аймгийн Алтай, Булган, Буянт, Дөргөн, Жаргалант, Зэрэг, Мөнххайрхан, Мянгад, Үенч, Ховд, Чандмань сумдаас 170 өрхийн 562 хүнийг хамруулахаар товлож, судалгаанд хэрэглэгдэх хэрэгслийг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн талаар хүсэлт ирүүлсэн байгууллагуудыг тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлж 15 байгууллагын тусламж үйлчилгээний талаарх шийдвэрийг Засаг даргын захирамжаар баталгаажуулж хүргүүллээ.

			Хугацаа болоогүй					ОНОО			
				0	30	70	100				
1	Монгол Улсын Шадар сайд	28		2		6	20	2420	86.4	4.3	B
2	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	14				3	11	1310	93.5	4.7	A
3	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	58			3	22	33	4930	85.0	4.3	B
4	Сангийн сайд	20				3	17	1910	95.5	4.8	A
5	Хууль зүй, дотоод хэргийн сайд	57	1	2	4	13	37	4730	85.7	4.3	B
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	31			1	7	23	2820	93.4	4.7	A
7	Батлан хамгаалахын сайд	25				12	13	2140	85.3	4.3	B
8	Барилга хот байгуулалтын сайд	46			2	8	36	4220	91.7	4.6	A
9	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	115			1	23	91	10740	93.4	4.67	A
10	Зам, тээврийн хөгжлийн сайд	26				2	24	2540	97.7	4.9	A
11	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	14				3	11	1310	93.6	4.7	B
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	14			3	3	8	1100	78.6	3.9	C
13	Эрчим хүчний сайд	14				1	13	1370	97.8	4.9	A
14	Эрүүл мэндийн сайд	48				13	35	4410	91.8	4.6	A
Дүн		510	1	4	14	119	372	45950	90.1	4.5	A

Хоёр. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн талаар:

Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны “Удирдамж, үзүүлэлт батлах тухай” 302 дугаар тушаалаар 16 төрлийн 32 шалгуур үзүүлэлт бүхий аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлагдсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2018 онд дунджаар 91.3 хувийн үнэлгээтэй байна. Үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

1. Эдийн засгийн үзүүлэлтээс: Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, төсвийн орлого бүрдүүлэлт, төсвийн хэмнэлт, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь, шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо, эрчимжсэн аж ахуйн тоо, эрчимжсэн малын тоо, хураан авсан малын тэжээл, бусад таримал, хураан авсан төмс, хүнсний ногоо, дэд бүтэц холбогдсон орон сууцанд амьдарч буй иргэдийн хувь зэрэг үзүүлэлтүүд өмнөх оноос өсөлттэй гарч, мөн онтой харьцуулахад 100 хувийн үнэлгээтэй байна.

Хэрэглээний үнийн индекс нь зорилтот түвшинтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй боловч өмнөх оныхоос 2,9-өөр буурсан ба 2017 онтой харьцуулахад 97,3 хувийн үнэлгээтэй байна. Энэ нь хэдийгээр 2018 онд цалин, тэтгэврийн хэмжээ тодорхой хэмжээгээр өссөн боловч баруун бүс тэр тусмаа Ховд аймгийн хэмжээнд

шатахууны үнийн өсөлт харьцангуй өндөр байсантай холбоотой өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өссөнтэй шууд холбоотойгоор хэрэглээний үнийн индекс өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан байна. Малын тоо өмнөх оноос 300200 тоо толгойгоор буурсан үзүүлэлттэй бөгөөд 91,3 хувийн үнэлгээтэй байгаа нь 2018 онд манай аймагт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн болон малын гоц халдварт, халдварт өвчин гарсантай холбоотойгоор буурсан байна.

2. Нийгмийн хөгжлийн үзүүлэлтээс: Хүний хөгжлийн индекс, сургуульд хамрагдалтын хувь, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо өмнөх оноос өссөн бөгөөд, бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, нялхсын эндэгдлийн түвшин нь өмнөх онтой харьцуулахад буурч, 100 хувийн үнэлгээтэй байна.

Иргэний шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент зорилтот түвшингээс өндөр боловч өмнөх онтой харьцуулахад буурч, 85,6 хувийн үнэлгээтэй гарсан байна. 2018 онд шилжиж ирсэн хүн нь шилжиж явсан хүнээсээ их бөгөөд хүн амын тоогоороо өмнөх оноос өссөн үзүүлэлттэй боловч өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа учраас үнэлгээний хувь буурч гарсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо буурсан боловч иргэдэд учруулсан хохирлын нөхөн төлөлт жил дараалан буурч байгаа нь зөрчлийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй болон өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, иргэдийн нөхөн төлөх чадвар, амьжиргааны түвшин буурч байгаатай холбоотой юм.

Эхийн эндэгдлийн түвшин өссөн ба өмнөх онтой харьцуулахад 0 хувийн үнэлгээтэй гарсан нь 2018 онд эхийн эндэгдлийн 3 тохиолдол гарсан бөгөөд 1 их эмч, эмнэлгийн ажилтнуудын буруутай, хариуцлагагүй үйлдлээс эмнэлгийн тусламжийг оройтож авсан, 2 эх архаг суурь өвчинтэй байсны улмаас эндсэнтэй холбоотой бөгөөд цаашид зайлшгүй анхаарал хандуулан, эхийн эндэгдэл гаргахгүй байх талаар зорилт тавьж ажиллах шаардлагатай.

Халдварт өвчний гаралт, халдварт өвчнөөр өвчлөгчдийн түвшин зорилтот түвшингээсээ буурсан үзүүлэлттэй боловч өмнөх онтой харьцуулахад өсч, 82.2 хувийн үнэлгээтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдагсдын тоо өмнөх оныхтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдээ албан ёсоор эмч, эмнэлгийн байгууллага, халамж, асаргаа, сувилгааны чиглэлээр албан ёсоор бүртгүүлэхгүй байгаатай холбоотой бөгөөд халамжийн мэргэжилтнүүд, холбогдох төслийн байгууллагуудтай хамтран тандалт судалгаа хийсний үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо жил ирэх бүр нэмэгдэж гарсантай холбоотой юм.

Гурав. Ховд аймгийн 2018 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар: Шилэн дансны тухай хуулийн хүрээнд аймгийн хэмжээнд 137 төсвийн байгууллага, 5 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, нийт 142 байгууллага мэдээллээ тухайн байгууллагын цахим хуудсаар болон шилэн дансны нэгдсэн цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлж

ажилласнаар 2018 оны жилийн эцсийн байдлаар Ховд аймагт Шилэн дансны тухай хууль 88.29 хувьтай хэрэгжсэн байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулдаг 142 байгууллага мэдээллээ бүрэн оруулж, тайлангаа илгээсэн нь аймгийн Засаг даргын Тамгын газар болон Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны мэдээлэлд байнгын хяналт тавьж, сум, байгууллагуудын дарга удирдлага, нягтлан бодогч нарт шилэн дансанд мэдээлэл оруулах, илгээх талаар заавар, зөвлөгөө өгч ажилласны үр дүн юм.

Мөн тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймгийн Хөшөөт хөгжил сан, Булган сумын 2 дугаар цэцэрлэг шинээр бүртгүүлж, Чандмань БИТ, Ховд-Эрч хүч, Үенч эрчим хүч ОНӨААТҮГ-ыг хасуулах хүсэлтийн захиалга илгээн, хасуулж ажилласан байна.

Дөрөв. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар: Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлд тусгагдсан 14 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 211 арга хэмжээний биелэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар тооцон, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн 2018 оны хэрэгжилтэд үнэлэлт өгөх тухай” 8/03 дугаар тогтоолоор үндсэн чиглэлийн биелэлтийг 80.0 хувийн биелэлттэй “хангалттай” үнэлгээтэй дүгнүүлсэн байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 11.4 хувь буюу 24 арга хэмжээ 40 хувь, 40.8 хувь нь буюу 86 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй, 43.1 хувь буюу 91 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үндсэн чиглэлийн биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар тооцож аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд 80.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн нь жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ нь аймаг орон нутгаас шалтгаалаагүй санхүүжилт, ажил хариуцсан албан хаагчдын идэвх санаачлагагүй ажилласан болон зарим арга хэмжээ орон нутагт хэрэгжих боломжгүйтэй холбоотойгоор хэрэгжилтийн явц удааширсан байна.

Тав. Аймгийн засаг даргын Тамгын газрын болон хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээний хэрэгжилтийн талаар: Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ 93.3 хувь, хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ 94.0 хувь, дунджаар 93.6 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 10 шалгуур үзүүлэлт 90.0 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

2019 оны 03 дугаар сарын байдлаар Засгийн газрын тогтоол 21, хуралдааны тэмдэглэл 2, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал 1, Тэргүүлэгчдийн тогтоол 41-ийг хүлээн авч хяналтын карт хөтлөн, аймгийн удирдлагуудад танилцуулж, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Долоо: Сумдын мэдээлэл:

Булган сум: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг сумын хэмжээнд тэмдэглэн 9 алдартан ээжийг шагнаж урамшуулан алдаршуулав. 2018 оны сумын тэргүүний манлай ээжээр Г.Цэцэгмаа, ачлалт ээжээр С.Асалгүл, энэрэлт ээжээр Б.Чулуунцэцэг, дархан ээжээр М.Боодоо, буянтай ээжээр Н.Хандаа, наран ээжээр С.Нацагням, саран ээжээр Н.Бадамханд, халамжит ээжээр Ц.Дорж, оюунлаг ээжээр И.Долгормаа нар тодорлоо.

Хөдөөгийн алслагдсан малчин эмэгтэйчүүд, ард иргэдийг хууль эрх зүйн мэдээллээр хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийг аливаа эрсдлээс өөрийгөө хамгаалах, зан үйлд сургах, мэдлэг чадвар олгох зорилгоор “Малчин эмэгтэйчүүдийн анхдугаар чуулга, уулзалт”-ыг зохион байгуулсан. Чуулга уулзалтанд нийт 370 гаруй малчин эмэгтэйчүүд хамрагдлаа. Анхдугаар чуулга уулзалтын үеэр малчин эмэгтэйчүүдийн дунд гар бөмбөг, шатар, даамны тэмцээн, “Авъяаслаг малчин” шоу арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, үр хүүхдийнхээ аяны алтан шар замыг сүүн цацлаар гэрэлтүүлж, нутаг ус, олон түмний ажил үйлс, амар амгаланг даатгаж, уул, ус, лус савдаг, тэнгэр бурхан, өвөг дээдэстээ “Сүүн цацал” өргөх арга хэмжээг мөн зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 150 гаруй эмэгтэйчүүд оролцлоо.

Монгол улсад зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны 98 жилийн ойн арга хэмжээний хүрээнд сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан ерөнхий боловсролын дунд сургуулийн 12 дугаар ангийн сурагчдыг Хилийн цэргийн 0130 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулсан тус арга хэмжээнд нийт 80 гаруй сурагчид хамрагдлаа.

Сумын нийт алба хаагчдын дунд “Марш тактик”, “гар бөмбөг”-ийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж тэмцээнд нийт 52 баг тамирчид оролцлоо.

Монгол орон даяар “Гамшгаас хамгаалах зарлан мэдээлэх дуут дохиогоор” ажиллах дадлага сургуулийн цугларалтад нийт аж ахуйн нэгж байгууллага мөн төрийн байгууллагын алба хаагчид хамрагдав.

Дөргөн сум: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, эмэгтэйчүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, сургалт, мэдээлэл өгөх зорилгоор сумын ИТХ, ЗДТГ, эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран 2 өдрийн арга хэмжээг зохион байгууллаа. 03 сарын 07-ны өдөр “Гар бөмбөг”-ийн тэмцээн, “Миний ээж хөөрхөн” эх үрсийн урлагийн тоглолт, 03 сарын 08-ны өдөр баярын хурал, Хувь хүний хөгжлийн институтын захирал, сэтгэл зүйч М.Алтанцэцэг “Эмэгтэй хүний үнэ цэнэ” сэдвээр лекц уншлаа. Уг өдрөөр Агваш багийн өндөр настан Л.Цэнд “Дархан

ээж”, Г.Жаргал “Халамжит ээж” Сээр багийн өндөр настан Х.Тогтох "Саран ээж”, Б.Маамуу “Буянтай ээж”, Аргалант багийн өндөр настан Ч.Сэмбэрүүн “Ачлалт ээж” С.Жавзансүрэн “Наран ээж”, Ч.Цэвэлмаа “Манлай ээж” Өгөөмөр багийн өндөр настан Ч.Хурмаш “Энэрэлт ээж”, Д.Алтанхүү “Оюунлаг ээж” –ээр тус тус шалгарч, энгэрийн тэмдэг, үнэ бүхий зүйлээр шагнаж өргөмжлөв. Мөн Шувуухай цэцэрлэгийн багш Б.Удвал “боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнагдлаа.

Монгол улсад Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны түүхт 98 жилийн ой, Монгол цэргийн өдөрт зориулан Аргалант багийн сумын начин Л.Сайнхүү агсны нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг ЗДТГ, Шандас бөхийн холбоо, сумын начин Л.Сайнхүү агсны үр хүүхдүүд хамтран зохион байгууллаа. Хүчит бөхийн барилдаанд 48 бөх барилдаж, Дөргөн сумын начин Ж.Эрдэнэбаатар түрүүлж, залуу бөх Б.Сэрэгжид үзүүрллээ.

Эх орончдын өдрийг тэмдэглэх, хөдөөгийн багуудын иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 03 сарын 01-ны өдөр Хүчит бөхийн барилдаан, багуудын дунд караоке дууны тэмцээн, танин мэдэхүйн АХА тэмцээн, сурагчдын дунд "Миний бахархал - Миний нутаг" эссе бичлэгийн уралдааныг зохион байгууллаа.

Гамшгийн аюулын зарлан дохиогоор ажиллах дадлага сургуулилтийг 03 сарын 22-ний өдөр сумын төв талбайд зохион байгууллаа. Уг ажиллагаанд 10 машин, 31 хүүхэд, 113 иргэд оролцлоо.

Тэтгэврийн даатгалын сангаас 2019 оны 03 сарын байдлаар нийт 388 тэтгэвэр авагчдад 123706,9 мян төгрөгийн санхүүжилтээр тэтгэвэр бүрэн тавьж олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 281, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 33, тахир дутуугийн тэтгэвэр авагч 74 иргэнд үйлчилж, тайлант сард 3 хүнд шинээр өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр тогтоож ажиллав.

Сайн дурын даатгалд нийт 13 даатгуулагчийн 723,8 мян төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 520,6 мян төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлсэн. Шинээр 3 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж ажиллав. Эрүүл мэндийн даатгалд 15 даатгуулагчийн 373,6 мян төгрөгийн орлого оруулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас 4 хүний оршуулгын тэтгэмжид 4000,0 сая төг, 3 даатгуулагчдад жирэмсэн амаржсаны тэтгэмжид 3135,7 мян төг, 1 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжид 55,8 мян төгрөг тус тус олгосон.

Төсвийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын гар утсанд нийгмийн даатгалын аппликейшн суулгаж, ашиглалт, ач холбогдолын талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Жирэмсэн амаржсаны тэтгэмж авахаар материалаа ирүүлсэн 9 эхийн тэтгэмжийг WAIS программд шивж орууллаа. Нийт 56 эхэд жирэмсний тэтгэмж олгогдож байна.

Цалинтай ээж хөтөлбөр хамрагдаж байгаа 176 эхийн нэрсийг гаргаж, программд шивж, олгоход бэлэн болгоод байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 40 өрхийн 245 иргэнд 2,8 сая төгрөгийн хүнсний бараа олгож, тайланг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүллээ.

Нийгмийн халамжийн сангаас олгогддог тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтүүд хугацаандаа бүрэн олгогдож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх туршилтын судалгаанд 02 дугаар сарын 10-аас 03 сарын 19-ы өдрийг хүртэлх хугацаанд 108 өрхийг хамруулж судалгааг амжилттай дуусгасан.

Мал эмнэлгийн тасгийн дарга, тархвар зүйч, Байгаль хамгаалагч, Байгаль орчны байцаагч, Агваш багийн тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч нар 02 дугаар сарын 27-ны өдөр хулс зэгсэнд өвөлжиж байгаа 25 малчин өрхөөр эргэлт хийж, гахайн сальмонеллэз өвчин, гал түймрийн аюул, орчны хог хаягдлын талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд ард иргэдийн дуудлагад цаг алдалгүй шуурхай үйлчилж тайлант сард 30 дуудлага хүлээн авч, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүллээ.

Малын хорогдлын мэдээг 7 хоног бүрээр авч нэгтгэн, тайлан мэдээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж байна. 3 дугаар сарын байдлаар тэмээ 1, адуу 44, үхэр 79, хонь 674, ямаа 784 нийт 1582, хээлтэгч ингэ 1, гүү 14, үнээ 32, эм хонь 321, эм ямаа 784 нийт 674, төл мал тугал 3, хурга 738, ишиг 806 мал нэмэгдсэн дүнг мэдээтэй байна.

Тайлант сард төрөлт 8, нас баралт 4, иргэний үнэмлэх олголт 10, захиалга 14, шилжиж ирсэн 8 нийт 42 бүртгэл хийж ажиллав.

Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд сумын нутаг дэвсгэрийн хур хог хаягдлыг цэвэрлэж, тус арга хэмжээнд албан байгууллага, албан хаагч, ард иргэд хамрагдаж нуурын эргэн тойрон, цагаан хаалга, дэнж, өргөст хошуу зэрэг газруудад хуваарийн дагуу цэвэрлэгээ хийж, хурсан хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлж устгав.

Багийн Засаг дарга нар багийн айл өрхүүдээр эргэлт хийж, малчдаас өвс тэжээлийн захиалга авч, хуваарьт тэжээл өвсийг багийн айл өрхүүдэд тараасан.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн аймгийн чадавх бэхжүүлэх багаас “Орон нутгийн хөгжлийн санг иргэдийн оролцоотой төлөвлөх”, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээ болон тэргүүлэх чиглэлээр эрэмбэлэх нь” сэдэвт сургалтанд сумын ЗДТГ-ын дарга болон багийн Засаг дарга нар болон байгаль орчны байцаагч нар хамрагдаж сургаж чадавхжууллаа.

Дэлхийн зөн ОУБ-ын “Үхэр төсөл”-д хамрагдсан айл өрхүүдийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 03 дугаар сарын 21-ны өдөр сургалт зохион байгуулж, өрхүүдийн дунд 2 бүлэг байгууллаа.

Ардын наадгайг хөгжүүлэх, сурталчлах зорилгоор Ерөнхий боловсролын сургуультай хамтран аймгийн Өв соёлын хүрээлэнгийн дэргэдэх монгол наадгайн

сургагч багш ардын тоглоом судлаач Д.Чулуунбаатарыг урьж ЕБС-ийн 20 багш, 150 сурагчид, 160 гаруй албан хаагч, ахмад настан, иргэдэд ардын уламжлалт наадгайн сургалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр 03 дугаар сарын 05-ны өдрийг “Монгол наадгайн өдөр” болгон тунхаглаж, 50 гаруй хүүхдэд олон санаа, морьтон, арилжаа зэрэг шагайн төрлийн тоглоомуудыг зааж сургасан болно.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Миний ээж хөөрхөн” эх үрсийн урлагийн тоглолт арга хэмжээ зохион байгуулж, 200 гаруй ээжүүдийг хамрууллаа.

Соёлын үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, ард иргэдийн авъяасыг нээн илрүүлж, хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сар бүрийн 15-ны өдрийг “Караоке дуулах өдөр”, сар бүрийн 20-ны өдрийг “Бүжиглэх өдөр”, сар бүрийн 25-ны өдрийг “Киноны өдөр” болгон зарлаж, уг арга хэмжээнд иргэдийг өргөнөөр хамруулан амжилттай зохион байгууллаа.

БСУГ-ын газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн музейн ажилтантай хамтран үзмэрийн санд тооллого хийхэд 65 үзмэр тоологдож, бүртгэлжүүллээ. Долоо хоног бүрийн 5 дахь өдрийг уншлагын өдөр болгон аян өрнүүлж тайлант сард 260 гаруй сурагч, ард иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

Багш нарын сургалтын чанар, сурлагын түвшинг тодорхойлох зорилгоор 1-12 дугаар ангийн сурагчдын дунд “цээж бичиг”, 1 ангиас “минутын уншлага, 6-11 дүгээр ангиас “Математик, Англи хэл, Монгол бичиг”, 7-10 дугаар ангиас “Нийгмийн ухаан”-ны шалгалтуудыг авч, хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт өгч ажиллав.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газраас 8 дугаар анги төгсөгчдөөс “Физик, Математик, Биологи” 9 дүгээр анги төгсөгчдөөс “Байгалийн ухаан”, 10 дугаар анги төгсөгчдөөс “Нийгмийн ухаан”-ны хичээлүүдээр хөндлөнгийн шалгалт авсан.

Боловсролын үнэлгээний төвөөс суурь боловсролын сурлагын чанарт үнэлгээ хийж 9 дүгээр анги төгсөгчдөөс “Математик, Монгол хэл”-ний шалгалт авсан. Шалгалтанд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийхээр аймгийн 6 дугаар сургуулийн сургалтын менежерээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж эцэг эх, сурагч, багш нарын төлөөллөөс санал асуулга авч ажиллав.

Эрдэнэбүрэн сумын математикийн багш Сандуй агсны нэрэмжит математикийн зүүн бүсийн олимпиадад сургуулийн төлөөлөл амжилттай оролцож, 5 алт, 3 хүрэл медаль хүртлээ.

“Амны хөндийн ариун цэвэр”, “Гар угаах дараалал” сэдэвт сургалтыг Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, Нийгмийн бодлогын ажилтан нар цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 110 хүүхдийн дунд зохион байгуулж, витаминжууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв тайлант сард амбулаториор 235 иргэнд үйлчилгээ үзүүлж алсын дуудлагаар 17, ойрын дуудлагаар 50 иргэнд эрүүл мэндийн тусламж үзүүлж ажиллав. Үүнээс 37 иргэн хэвтэн эмчлүүлсэн.

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант сард шинээр 4 эхийг хяналтанд авч, эх хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж байна. Товлолын дархлаажуулалтанд 0-2 хүртэлх насны 39 хүүхдийг хамруулсан ба сайн

дурын дархлаажуулалт элэг хамгаалах В гепатитийн вакцинд 10 иргэнийг хамрууллаа.

“Эх, хүүхэд нөхөн үржихүйн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 10 жирэмсэн эхэд “Жирэмсэн үеийн хооллолт” сургалт зохион байгуулж энэ үеэр “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт гарын авлага бэлтгэн багийн эмч нараар дамжуулан ард иргэдэд мэдээлэл хүргэж ажиллав.

Чандмань сум: Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид тайлант сард 1 удаа хуралдаж Алдарт эхийн 1, 2 дугаар одонгоор шагнагдах ээжүүдийн материалтай танилцаж баталгаажуулан холбогдох дээд газарт хүргүүлээ. Мөн төсөвт байгууллагуудад ажил сайжруулах зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газар 4 багийн Иргэдийн нийтийн хуралтай хамтран “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, 280 гаруй иргэдийг хамруулж баг тус бүрээр орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх санал авах, төсөл хөтөлбөрийг эрэмблэх ажлуудыг зохион байгуулж Засаг даргын тамгын газрын жилийн ажлын тайлан мэдээллийг хэлэлцэж санал солилцов.

Орон нутгийн хэмжээнд цаг агаар эрс хүйтэрч цас их орсоны улмаас малчдын хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан хөдөөгийн багийн малчдийн цаг үеийн нөхцөл байдлыг газар дээр нь судлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор малчдад аймгийн онцгой комисс 30%-ийн хөнгөлөлт, улсын онцгой комисс 50%-ийн хөнгөлөлттэйгөөр 2300 пресс, 460 уут тэжээлийг 6 багийн малчдад тус тус хүргэлээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж шилдэг 9 ээжийн номинацийг шалгаруулан 6 багийн 250 гаруй ээжүүдийг хамруулан хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулж нийт төрийн байгууллага, баг, хорьтуудын дунд заавал сурах 10 бүжгийн тэмцээн зохион байгууллаа.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 15:00 цагт зохион байгуулан үйл ажиллагааны хүрээнд газар хөдлөлтийн үед нэн яаралтай авах 10 алхамыг танилцуулах, мэргэжлийн ангийн гишүүдийн тодотгол хийх, хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих 15 зүйлсийг шалгах зэрэг үйл ажиллагаануудыг амжилттай зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ажилласан.

Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах өдрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар анги, цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдэд газар хөдлөлтийн үед яаралтай авах 10 алхам, болон газар хөдлөлтийн үед, өмнө, дараа юу хийх, хэрхэн өөрсдийгөө болон бусдыг хамгаалах талаар сургалт мэдээлэл хийж гамшгийн үед хэрхэн ажил дадлага сургуулилтыг сургуулийн насны сурагчдад таниулан ажилласан.

2019 оны 03 дугаар сарын байдлаар орон нутгийн хэмжээнд Төрийн үйл ажиллагааг ил тод нээлттэй, хүртээмжтэй явуулах үүднээс иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, хамтран ажиллах, хяналт үнэлгээ тэгш хуваарилалтыг баримтлан ТА-ны үндсэн шалгуур үзүүлэлтэд тулгуурлан шийдвэрлэж, сумын нийт төсөвт байгууллагуудад 25 хүсэлт, өргөдөл гомдол ирснээс 23 иргэний санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч, 2 иргэний өргөдөл хүлээгдэж байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх 2018 оны Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан “Иргэний улсын бүртгэл” хөтлөх журмыг хэрэгжүүлэн иргэний гэр бүлийн 8 төрлийн бүртгэлийг иргэдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч холбогдох баримтыг шалган бүртгэлийг иргэдэд шуурхай хүргэж ажиллав. Тайлант сард шинээр төрсөн хүүхэд 1, нас баралтын бүртгэл 1, иргэний шинэчилсэн бүртгэл буюу хурууны хээ өгсөн 9 иргэнд үйлчлэв. Бүртгэл хийсэн маягтуудыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст тухай бүр хүргүүлэн журманд заасан хугацаанд үндсэн мэдээллийн санд тусгуулан үйл ажиллагааг хэвийн зохион байгуулан ажиллаж байна.

Жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг 13 иргэнд хүргэж 14833,7 төгрөг, Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг 8 иргэнд 307,4 мянган төгрөг, оршуулгын тэтгэмжийг 1 иргэнд 1.0 сая төгрөг олгов. Өндөр насны тэтгэвэр авагч 296, тахир дутуугийн тэтгэвэр авагч 39, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 15 иргэн нийт 350 иргэн Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байна.

Халамжийн тэтгэвэрийг 3 ахмад настан, 61 иргэн хөдөлмөрийн чадвар алдсаны, 18 иргэн тэжээгчээ алдсаны тэтгэвэр нийт 82 иргэн, 56 иргэн асаргааны мөнгөн тэтгэмжийг, 16 хүртэлх насны хүүхэд асарч буй 10, хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч буй 23, бүтэн өнчин хүүхэд асарч буй 1 бүгд 90 иргэнд, 16 нас хүрээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 8, асаргаанд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн 18, ахмад настан 28, гурав ба түүнээс дээш тооны 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг/ эх 4, жирэмсэн эхийн тэтгэмж 104 эхэд, цалинтай ээж хөтөлбөрт 199 иргэн тус тус хамрагдаж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль дотуур байрны хүнсний болон үдийн цай хөтөлбөрийн тендер шалгаруулалт зарлаж, дотуур байрны хоол хүнс нийлүүлэхээр “Чандмань хүрэмтийн тал”, “Чандмань овоот хайрхан” аж ахуйн нэгжүүд, үдийн цай хөтөлбөрийн шингэн бүтээгдэхүүн нийлүүлэхээр “Аагтай шаргал цай”, “Чандмань Жаргалантын ундарга” аж ахуйн нэгжүүд тус тус шалгарсан. Гурилан бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх багцад санал ирээгүй тул шууд худалдан авалт хийх шийдвэр гарсан болно.

2018-2019 оны хичээлийн жилд мэргэжлийн хичээлийн олимпиад, спортын бага наадам, Яргуй-2019 наадмын удирдамжийн хүрээнд бэлтгэл ажил хийгдэн олимпиад уралдаан тэмцээнд оролцож байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Яруу найраг утгын чимгээр-Яргуй насаа чимцгээе” уралдаанд бага ангиас М.Оюунцэцэг багштай 5а, Н.Бямбаа

багштай 3а, Н.Цагаанцоож багштай 2а ангиуд, дунд, ахлах ангиас Б.Нямдаваа багштай 8а, Д.Оюунбилэг багштай 12а, Г.Ариун-Эрдэнэ багштай 7а ангиуд тэргүүн байрыг тус тус эзэлж шагнаж урамшууллаа.

“Ээждээ захидал бичих” уралдааныг амжилттай зохион байгуулж, нийт 70 гаруй захидал ирж шилдэг захидлын эздээр багш Х.Сэлэнгэ, өндөр настан Б.Баяраа, иргэн Н.Эрдэнэчимэг, сурагч Н.Мөнхжин, Б.Янжмаа нар шалгарч шилдэгүүдэд шагнал гардууллаа.

Чадварлаг багш дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан шилдэг гарын авлага, зөвлөмж бичих уралдаанд багш Б.Тунгалаг, Ц.Байгалмаа, Д.Оюунбилэг, А.Энхбаяр, Д.Орломсүрэн нарын бүтээл шалгарлаа.

Сумын Эрүүл мэндийн төв анхан шатны тусламж үйлчилгээндээ мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж 1600 гаруй иргэдийг хамруулан ажилласнаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамны талархал хүлээн авлаа.

Эрдэнэбүрэн сум: “Эх орончдын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд эрэгтэй, эмэгтэй гар бөмбөг, шагайн харваа, шатар, теннисний тэмцээн, үдшийн цэнгүүн зэрэг спорт, урлагийн арга хэмжээг зохион байгууллаа. Тэмцээн, цэнгүүнийг аймаг дахь Нутгийн зөвлөлийн санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр мартын 8-ны баярын арга хэмжээг тэмдэглэх хөтөлбөр гаргаж сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хөтөлбөрийн дагуу дараах ажлуудыг зохион байгуулж 190 гаруй хүн оролцлоо. Үүнд: Гар бөмбөгийн тэмцээн, “Алдрын эзэд эмэгтэйчүүд-2019” баярын хурал хийж 9 номинациар алдарт ээжүүдийг шалгаруулж шагнав. Мөн “Манлай малчин” цол тэмдэгийг аймгийн аварга малчин 5 эмэгтэйд гардуулав. “Бүүвэйн дуутай хорвоо” эрчүүдийн хүндэтгэлийн концерт тоглогдож орой нь “Цэцэгс гэрэлтсэн үдэш” цэнгүүнээр тус арга хэмжээ өндөрлөв.

Соёлын төвийн бүжгийн дугуйланд хичээллэж буй 21 сурагчид 2019 оны 03 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Буянт, Мянгад, Дөргөн сумдын сургуулийн сурагчидтай нөхөрсөг тэмцээн зохион байгуулж “Язгуурын алтан хэлхээ” урлагийн тоглолтоо толилуулсан нь уламжлал, ёс заншлаа сурталчилсан, хүүхдүүд харилцан нэгнээсээ суралцсан нөхөрсөг арга хэмжээ боллоо.

“Аймгийн аварга багш” математикийн багш Б.Сандуй агсны нэрэмжит “Математик–бүх шинжлэх ухааны хаан” уриатай аймгийн зүүн бүсийн бүх сумдын “Математикийн олимпиад”-ыг 2019 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж Эрдэнэбүрэн, Дөргөн, Ховд сумдын сургуулийн 5-12 дугаар ангийн 50 гаруй хүүхэд өрсөлдсөн нь сурагчдын математик сэтгэхүйг хөгжүүлэх, харилцан туршлага солилцох үр дүнтэй ажил боллоо. Олимпиадыг Б.Сандуй агсны үр хүүхдүүд ивээн тэтгэж анги тус бүрт аваргуудыг шалгаруулан алт, мөнгө, хүрэл медаль, диплом, мөнгөн шагналаар шагнав.

Сумын ИТХ-ын дарга болон Засаг дарга нар 2019 оны 03 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд малчин мал бүхий өрхүүдээр морьтой явж малчдын хаваржилтын байдалтай танилцаж малчдын санал хүсэлтийг сонссож орон нутгийн бодлого үйл ажилагааг танилцуулав. Казак түмний “Наурыз баяр”-аар сумын Казак иргэдийн ахмадууд болох Шураг багийн аймгийн аварга малчин Б.Тлеухан, Хар ус багийн өндөр настан Х.Сейдла, аймгийн аварга ногоочин Ж.Ганболд нарт сум, багийн удирлагууд хүндэтгэл үзүүллээ.

Сумын хүүхдийн Цэцэрлэг 2019 оны 3 дугаар сараас “Өдөрт нэг аяга сүү” аян өрнүүлж хүүхдийг экологийн эрүүл хүнсээр хангах төдийгүй, тэднийг эрүүл өсч хүмүүжихэд ач холбогдолтой ажил боллоо. 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд сумын “Бошигтын мэргэд” шагайн холбоо 8-н хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай зохион байгуулж багийн харваанд 4 дүгээр байр, цуваа харваанд сумын харваач, аймгийн гоц мэргэн Ш.Мөнхбаяр 2 дугаар байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Байгаль орчны албанаас сумын Урт давын эхэн, Хаваржингийн эхэн, Хонгион хавцал, Харгайтын гол зэрэг зэрлэг ан амьтан байрлах байршил газарт 50 боодол өвс, 5 уут хужир тавьж биотехникийн арга хэмжээ зохион байгууллаа.

“Малчдадаа тусалъя” аян өрнүүлж сумын бүх байгууллагууд идэвхитэй оролцож нийтдээ 350ш гар чийдэн, хурганы уут 55ш, угжны хөх 146ш, сүү 53ш, төлийн элгэвч 16, шүдэнз 9 толгойг малчдад хандивлалаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль “Бид бүхнээс түрүүлж алхдаг” уриатай шилдэг үйл ажиллагаатай “Заах аргын нэгдэл” шалгаруулах 3 сарын хугацаат уралдаан зарлаж 2019 оны 05 дугаар сарын 11-нд дүгнэхээр олон хэлбэрийн арга хэмжээг зохион байгууллаа.

Багийн ИНХ-ыг 2019 оны 03 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд удирдамжийн дагуу зохион байгуулж, тус хуралд сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга, төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч нар, сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд оролцож сум байгууллага, салбарын мэдээлэл хийж иргэдийн санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа. “Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-ээр 4 машинтай 27 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Сумын Эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзлэг хийж, иргэдээс БЗДХ-ын болон эсийн шинжилгээ авахаас гадна иргэдэд эмийн санч эмээр үйлчлэв. Мөн “Малчиддаа тусалъя” аяны хүрээнд цугларсан эд зүйлсээс малчин өрхүүдэд хурганы уут, төлийн элгэвч, угжны хөх, сүү, нэмнээ, шүдэнз болон өрх бүрт сумын ИТХ, ЗДТГ-аас 1ш гар чийдэнг бэлэглэсэн зэрэг нь малчдын талархлыг хүлээсэн төрийн үйлчилгээ болж чадсан юм.

Дуут сум: Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, хурлаас 2019 оны 3 дугаар сарыг хэрэглэгчдийн эрхийг хамгаалах сар болгон зарлаж, сарын аяны нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Аяны хүрээнд ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургуультай хамтран “Хүүхэд хэрэглэгч” өдрийг зохион байгуулж, сурагчдийн дунд насны ангиллаар сургалт, АХА тэмцээн

зохион байгууллаа. Дээрх арга хэмжээнд 9-11 дүгээр ангийн 54, 8-6 дугаар ангийн 65 сурагчид хамрагдлаа.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын нийт эмэгтэйчүүдийн дунд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулж, сумын 9 алдартан ээжүүдэд хүндэтгэл үзүүллээ.

Иргэдээс сумын Засаг даргын Тамгын газарт нийт 7 өргөдөл хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэв.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах төлөвлөгөөт сургалт, зөвөлгөөн, семинарт холбогдох ажилтнуудыг чадавхижуулж байна.

Сумын Хүүхдийн цэцэрлэг Хүүхэд бүр цэцэрлэгт, Номын гэгээ, Авьяас, Чадварлаг багш дэд хөтөлбөрүүдийн хүрээнд 12 төрлийн ажил зохион байгуулахаар төлөвлөн 4 төрлийн үйл ажиллагаа зохион байгууллаа.

Багш нарыг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр 3 төрлийн 8 цагийн судалгаат ажил зохион байгуулж заах аргын нэгдлийн гишүүдээр хэлэлцүүлэн дүгнэж ажиллав.

Хүүхдийн хоолны амт чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулж нэмэгдүүлэн хоолны цэсийг шинэчлэн баталж, технологийн карт хөтөлж эхлүүлээд байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант сард сургалт, хүмүүжил, боловсролын бодлого чиглэлийн талаар нийт 20 ажил төлөвлөн хийж гүйцэтгэв. Үүнд: Боловсролын мэдээллийн системд багш нарын судалгааг шивж баталгаажуулсан, Монголын багш нарын 7 дугаар их хуралд оролцох төлөөлөгчдийг хэлэлцүүлж сонгон шалгарууллаа. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн боловсролын баримт бичгийн захиалга авч холбогдох газарт хүргүүлсэн төдийгүй БСШУС-ын сайдын “Хүүхэд хэрэглэгч” өдрийг тэмдэглэх тухай 2018 оны 121\А\780 тушаалын хэрэгжилтийг хангах сумын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн сарын аяны хүрээнд “Хэрэглэгчээ дээдэлсэн” ажлыг зохион байгуулж 1-11 дүгээр ангийн нийт сурагчдад сургалт сурталчилгаа, бага ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгуулав.

Сумын Эрүүл мэндийн төв 182 иргэнд Амбулторын үзлэг хийж, 21 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 5 иргэнд өдрийн эмчилгээгээр эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэв. Жирэмсэн 28 эхийг хяналтанд авч 4 эхийг эсэн мэнд амаржууллаа. “Эрүүл мэнд эрхэм баян” нээлттэй хаалганы сарын аяны хүрээнд Шивэр багийн ард иргэдэд их эмчээр ахлуулсан баг ажиллаж багийн нийт 40 өрхийн 82 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрууллаа. Энэ ажлын хүрээнд 24 хүнээс сэтгэл ханамжийн судалгаа авч, 32 хүнээс сүрьеэгийн урьдчилан сэргийлэх асуумж авахад сүрьеэгийн сэжигтэй байх тохиолдол илрүүлсэн төдийгүй 32 өрхөд хүүхдийн асаргаа, түлэгдэлт, артерийн даралт ихсэлт, зөв хооллолт, архи тамхины хор уршиг, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаарх сургалт зохион байгууллаа.

Жаргалант сум: “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.42 дэх заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн

2.4.2.2 дэх заалт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3 дэх заалт, “Биеийн тамир спортын тухай хууль”-ийн 8.1.2 дэх заалт, Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Өөрчлөлтийг өөрөөсөө” нэгдсэн уриан дор нэгдэн нийтийн биеийн тамир, спорт олон нийтийн арга хэмжээг эрчимжүүлэх, бүжгийн спортоор дамжуулан охид бүсгүйчүүд, эмэгтэйчүүдэд бие бялдар гоо зүйн боловсрол олгох, иргэд олон нийтийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд бүх насны эмэгтэйчүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор охид эмэгтэйчүүдийн нэгдсэн бүжгийн (плаш моб) уралдааныг тусгай хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгууллаа. Уралдааны бэлтгэл ажлын хүрээнд нийт 85 төрийн болон төрийн бус байгууллагад удирдамж хүргүүлсэн. Тэмцээнд нийт төрийн болон төрийн бус 27 байгууллагын 600 гаруй эмэгтэй ажилтан, албан хаагчид оролцоноос 1 дүгээр байранд Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэг, 2 дугаар байранд Жаргалант сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль, 3 дугаар байранд Лаборатори 1 дүгээр сургууль, тусгай байранд 2,11 дүгээр цэцэрлэг, шилдэг хөгжөөн дэмжигч байгууллагаар 2 сургуулийн сургуулийн хамт олон тус тус шалгарлаа.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр болон, “Тайван амгалан Ховдчууд” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн элч, Цагдаагийн дэд хурандаа М.Оюунсүрэн, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Ховд аймаг дахь хүний эрхийн хороотой хамтран “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг Политехник коллежийн 200 гаруй оюутан сурагчдад зохион байгууллаа.

Олон улсын нийгмийн ажилтны өдрийг тохиолдуулан Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан аймгийн ЗДТГ-тай хамтран “Хүн хоорондын харилцааны ач холбогдлыг чухалчлах нь” уриан дор нийгмийн ажилтны анхны зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, 12 багийн нийгмийн ажилтан, Эрүүл мэнд, Боловсрол, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газарт ажиллаж байгаа мэргэжлийн 64 нийгмийн ажилтан оролцсон. Хэлэлцүүлгийн хүрээнд аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох заалтуудыг танилцуулж нийгмийн ажилтанд тулгамдаж байгаа асуудлын талаар ярилцаж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар төлөвлөгөө боловсрууллаа.

Аймгийн аюулгүйн нөөцөөс хуваарилагдаж ирсэн 150 уут тэжээл, 850 пресс өвсийг 131 малчин болон мал бүхий өрхөд, 100 уут тэжээлийг 80 өрхөд хөнгөлттэй үнээр олгов.

Ховд сум: Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж, ИТХ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Зарим иргэдийг төрийн одон медалиар шагнуулах тухай, Алдарт эхийн одонгоор шагнуулах тухай, Багийн ИНХ-ын 2018 оны ажлын тайлан, 2019 оны төлөвлөгөө хэлэлцэх, сумын өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн

батлах тухай, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийг шинэчлэн баталж 2019 оны төлөвлөгөө батлах тухай, суманд 2019 онд хийх хяналт шалгалтын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн тайлан, төлөвлөгөө батлах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг томилж, Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэхэд холбогдуулан УИХ, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм, журмуудыг таниулах мэдээлэл өгөх сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр сумын “Иргэний танхим”-д зохион байгуулав. Сургалтанд нийт 36 төрийн албан хаагч хамрагдав.

Сумын Засаг даргын Тамгын газраас Наурыз баярыг угтаж албан байгууллага, аж ахуй нэгжүүд нийтийн цэвэрлэгээг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр, айл өрхүүд 2019 оны 03 дугаар сарын 16-ний өдрүүдэд тус тус зохион байгуулав.

Тайлант сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших, өмчлөх, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хүссэн 12 өргөдөл хүсэлт хүлээн авч 9 өргөдлийг сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших эрхийг олгов. 1 иргэний газар өмчлөх эрхийг өөрийн хүсэлтээр хүчингүй болгож, 2 иргэний хүсэлтийг багийн албад багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулахаар сумын Засаг даргын албан тоотоор хүргүүлэв.

Ил тод, нээлттэй ухаалаг газрын харилцаа зорилтын хүрээнд өрх толгойлсон хоёр ээжид тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орж батлагдсаны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээ, газар өмчлөх эрхийн Улсын бүртгэлийн хашааны гэрчилгээ тус бүрийг олгож гардуулав.

Сумын Эрүүл мэндийн төв нь 22 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 225 иргэнд үзлэг оношилгоо хийж 54 удаагийн алсын дуудлагад, 23 удаагийн ойрын дуудлагад явж ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлээ. Товлолын вакцинд 66 хүүхдийг хамрууллаа.

Сумын Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчид үйл ажиллагааг сар, 7 хоногоор төлөвлөн “Чадварлаг Ховд”-чууд хөтөлбөрийн хүрээнд алтан өв урлагийн наадамд бэлтгэж байна. мөн “Номын гэгээ” хөтөлбөрийн хүрээнд 4 үлгэрийн сэдвээр даавуун ном хийж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд: Бага бүлэг манжин, дунд бүлэг өнхрүүш, бэлтгэл бүлэг эвтэй дөрвөн амьтан, гурван баавгай сэдвүүдээр ширээний ном хийж сургалтанд ашиглахаар бэлтгээд байна.

Манхан сум: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр 9 алдарт ээжид Засаг даргын өргөмжлөл гардуулж хүндэтгэл үзүүллээ. Улсын нөөцөөс хуваарилагдаж ирсэн 1400 пресс, 284 уут хорголжин тэжээлийг малчин айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр олголоо.

Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Мал эмнэлэгийн тасгийн дарга, тархвар зүйч, багийн Засаг дарга нар хамтран багуудын малчин мал бүхий өрх айлаар орж амьдрал ахуйтай танилцаж аймаг орон нутгийн хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар малчдад мэдээлэл хүргэж тэдний санл хүсэлтийг сонслоо.

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж аудитаар баталгаажуулан санхүү, төрийн сангийн хэлтэст тушааж ажлаа дүгнүүлэв.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдад “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Архи тамхины хор уршиг”, “Эерэг сэтгэлгээ, харилцаа хандлагын ид шид” сэдэвт сургалт, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, хулгайн гэмт хэрэг, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар нийт 300 сурагчдад яриа таниулга хийв.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард 321 үйлчлүүлэгчдэд амбулторын үзлэг шинжилгээ хийж урьдчилан сэргийлэх үзлэгт 183 хүн хамруулсан ба 42 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 41 хүүхэд хамрагдсан, 2 эхийг эсэн мэнд амаржуулж, алсын 5 дуудлаганд үйлчиллээ. Томуу томуу төст өвчний тандалтын мэдээг 7 хоног бүр холбогдох байгууллагад хүргэн ажиллаж байна. 0-5 насны хүүхэд болон жирэмсэн эхчүүдийг багийн эмч нар 7 хоног бүр гэрийн идэвхитэй эргэлтээр үзэж, хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу төвийн хог хаягдал, орчны мал амьтны сэг зэмд үзлэг хийж орчны цэвэрлэгээг зохион байгуулав.

ДБХС-ийн дэмжлэгтэй 2 газар камер байршуулж бөхөнд өвс тавих ажлыг хийж гүйцэтгэлээ.

Малын зүй бусын хорогдолын мэдээг сар бүр гаргаж холбогдох газарт хүргүүлж ажилласан ба 3 сарын байдлаар гаргахад адуу 161, үхэр 215, тэмээ 4, хонь 1974, ямаа 4746 нийт 7100 мал хорогдсон дүн мэдээтэй, мөн сумын хэмээнд 1585 эх мал төллөснөөс 1179 төл бойжиж 406 төл хорогдсон дүн мэдээтэй байна.

Мөнххайрхан сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус хуралдаан 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж, Төлөөлөгчийг чөлөөлөх тухай, Зарим газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа хуралдуулж, 8 асуудлыг хэлэлцэн, ажлын төлөвлөгөө, алдарт эхийн одонд тодорхойлох зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сумын Засаг даргын Тамгын газрын аппаратын хуралдааныг 1 удаа, шуурхай хуралдааныг 1 удаа хуралдаж, дотоод сургалт, тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах талаар хэлэлцэн, сумын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар нийгэмлэг, хүний эрхийн салбар хороо хуралдаж, ажлын төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх, аян өрнүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сумын хэмжээнд Засаг даргын 2019 оны А/19 дүгээр захирамжаар “Хуулиа мэдье, мөрдье” аян өрнүүлэн 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Тамгын газарт аялуулж эхлүүлээд байна.

Сумын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар нийгэмлэг хуралдаж, төрийн байгууллага, үйлчилгээний байгууллага, дэлгүүр, халуун ус, тоглоомын газар, нийтийн хоол үйлдвэрлэгч газруудад хяналт шалгалт хийж, үйлчилгээний норм стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж буй байдал, галын аюулгүй байдал,

хаягжуулалтын тухай хууль, монгол хэлний тухай хууль, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль, боловсрол, эрүүл мэндийн салбарын хууль, тамхины хяналтын хууль зэрэг хуулиудын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, хууль стандартын дагуу заавар, зааварчилгаа, хуулийн зөвлөгөө өгч ажиллав.

Тогтвортой амьжиргаа-3 төслөөс санхүүжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг эрэмбэлэх, сумын Засаг даргын Тамгын газрын ажлын хэсгийг чадавхжуулах сургалтанд 10 ажилтан, албан тушаалтныг 03 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд сургалтанд хамруулж, чадавхжууллаа.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, 30 дугаар зүйлийн 30.1.6, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, 2017 оны “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай” 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/181 дүгээр захирамжийг үндэслэн 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 15.00 /орон нутгийн цагаар/ цагаас сумын хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах дадлага сургуульд иргэн бүрийг оролцуулахаар тогтоосон тул мэдээллийг иргэдэд хүргэж, үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс баталсан 15 нэр төрлийн зүйлийг бэлтгэн, аранз үүрч дохио дугарч, талбайд цугласны дараа бэлтгэл хангаж, дудлага сургуульд оролцсон байдлыг шалгах ажил зохион байгуулах талаар танилцуулав.

Суманд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтын дуут дохиог Зил-130 авто машины хөл сигналаар өгч, сургуулилтанд нийт 11 байгууллагын 296 иргэн оролцож, үүнээс 171 том хүн, 125 хүүхэд, 7 тээврийн хэрэгсэл үүнээс 1 ачааны авто машин, 1 суудлын авто машин, 5 мотоцикль дайчлагдан оролцов.

Оролцогч 11 байгууллагаас төлөөлөл болгон 11 хүний аранзанд үзлэг хийж, бэлтгэлийг шалган, 15 нэр төрлийн зүйлсийг хэрэглэх талаар танилцуулж, дадлага олгох зорилгоор 2 хүнийг байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны ажлын байранд нууж, сумын аврах бүлгээр аврах ажиллагаа явуулж, эрүүл мэндийн алба яаралтай тусламж үзүүлэх сургуулилт явуулав. Сумын Хүүхдийн цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагууд “Газар хөдлөлтийн гамшиг” ослын талаар сургалт зохион байгуулж, багш, хүмүүжигч, ажилтнууддаа мэдээлэл өгөв.

Дадлага сургуулилтанд оролцсон нийт иргэдэд Газар хөдлөлийн үеийн аюулгүй ажиллагааны “Нуугд-Суу-Хүлээ” зарчмыг баримтлан орон сууц, өрөө тасалгаандаа аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалах арга хэмжээг авч, ширээн доогуур орох, даацын хана, булан тохойд 10 минут зогсож, дараа нь гэр орон, барилга, объектыг орхин гарч, гарахдаа гарын доорх материал ашиглан толгойгоо хамгаалан даацын хана дагуу “Гүйхгүй, эргэж буцахгүй, Хашгиралдахгүй, Түлхэлцэхгүй” гэсэн зарчмаар барилгын гарц, хаалгаар, гарч аюулгүй талбайд бэлэн байдлыг ханган оролцсон

иргэдэд талархал илэрхийлж, цаашид бэлэн байдлаа ханган, хоол хүнс, сонин, радио зэрэг чухал хэрэгслүүдийг хангалттай бэлтгэн аранзтай болох талаар мэдээлж ажиллав.

Сумын орон нутаг судлах танхимын хөдлөх дурсгалын улсын тооллогыг 03 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулж, 189 ширхэг үзмэр байхаас 12 үзмэр дутаж, 177 ширхэг үзмэр тоолж, бүртгэлийг сэргээн баталгаажуулав.

Сумын Номын санд 5 уншигч шинээр карт нээлгэж, 10 уншигчдад 31 ном хэвлэлээр үйлчлэв.

Ерөнхий боловсролын сургуулийн өмнөх боловсрол олгох чиглэлд анхаарч олон улсын “Хэрэглэгчийн өдөр”-ийг тохиолдуулан “Хүүхэд хэрэглэгч” аян өрнүүлж, сургуулийн сурагчдад хэрэглээний соёлыг төлөвшүүлэх талаар мөн хүнсний аюулгүй байдал ба хүүхэд сэдвээр сургалт зохион байгуулж, мэдээлэл өгч, үдийн цай нийлүүлэгч, хүнс худалдаалагч нарт хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, баталгаатай хүнс нийлүүлэх талаар санал солилцож, хүүхдийн эрх ашгийг хүндэтгэж, хориотой, хугацаа хэтэрсэн, хүүхдийн ходоодны хелико бактери их байгаа нь хүнсний хэрэглээ, ахуйн ариун цэврийг сахих талаар эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл өглөө.

Мөнххайрхан уулын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Засаг даргын Тамгын газрын хамтарсан ажлын хэсэг 3 дугаар сарын эхний 19 хоногт цаг агаар хүндэрч, цас орж, хүйтний эрч нэмэгдсэнтэй холбогдуулан зэрлэг амьтдын буйр нутгаар тойрч, 3 чиглэлийн 7 цэгт 30 пресс өвс, хужир шүү тавьж, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

Сумын Эрүүл мэндийн төв нь эмийн бус эмчилгээгээр 33 насанд хүрэгчид, 6 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүллээ. Урьдчилан сэргийлэх зорилгоор 0-2 насны 24 хүүхдэд товлолын дагуу дархлаажуулалтанд 100 хувь хамрууллаа.

“Өсвөрийн эрүүл мэнд” 1 сарын аян өрнүүлж өсвөр үеийнхэнд түгээмэл тохиолдох өвчлөлийг тандах, улмаар эмчлэн эрүүлжүүлэх зорилготойгоор Ходоодны хеликобактер, цусанд сахар тодорхойлох, БЗДХӨ илрүүлэх шинжилгээнүүдийг хийж, биеийн ерөнхий үзлэг, өндөр, жин тодорхойлсон үзлэг хийв.

Энэхүү үзлэгт ерөнхий боловсролын 6-12 дугаар ангийн бүх сурагчдыг 100% хамруулж, үзлэгээр 5 хүүхэд тутмын 3 нь хеликобактертэй гарсан, өсвөр үеийнхний дунд ходоодны өвчлөл их байгаа нь тогтоогдсон. Өвчлөлийг бууруулах зорилгоор эцэг, эхчүүд, багш нарт мэдээлэл өгч давтан шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн “Эрүүл хүүхэд-Монголын ирээдүй” 7 хоногийн аянд 6 хүүхэд хамрагдсан ба хүүхдүүдийн өвчлөл бүрт тохирсон эмийн бус эмчилгээнд эмчийн заалтаар хамруулж, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулсан. Аяны үр дүнд хоолонд дургүй байсан 2 хүүхдийн хооллолтыг сайжруулж, олон төрлийн тэжээллэг хоол бэлдэж өгөх арга барилд сургасан.

Хүн амын дархлааны тогтоцыг илрүүлэх сорьц авахаар Борт багийн сонгогдсон 10 өрхийн 35 сорьцыг авсан. Сорьц авах ажлыг сумын Засаг даргын Тамгын газар, Борт багийн эмчтэй хамтран багийн өрхүүдээр гэрийн идэвхитэй эргэлт зохион байгуулсан.

Сумын “Хатан сэнхэр” эмэгтэйчүүдийн байгууллагаас Манхан, Мөст, Мөнххайрхан, Цэцэг, Дуут 5 сумын эмэгтэйчүүдийн уулзалт зохион байгуулж, спорт, урлагийн 3 төрөлт арга хэмжээ, “Дэвжээ” тэмцээнүүдийг зохион байгуулж, 4 сумын 80 гаруй эмэгтэйчүүд оролцлоо.

Мөст сум: Төрийн албаны тухай шинэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн алба хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Өвөлжилт, хаваржилт хүндрэлтэй байгаан улмаас улсын нөөцөөс малчдад зориулж 1400 өвс, 280 уут тэжээл татан авч малчдад хөнгөлөлтэй үнээр олгов

Эмийн хөнгөлөлтийг иргэдэд 100% олгож, 1084 хүүхдэд хүүхдийн мөнгө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргаг бүрэн олголоо. Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр төрөлт-6, гэрлэлт-2, гэрлэлт цуцлалт-1, шилжин ирсэн-2 иргэний үнэмлэх-12, овог нэр өөрчлөлт-1, үрчлэлт-1 нийт-25 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 3 даатгуулагч хамрагдсан ба нийт 22 даатгуулагчийн 2381,5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 22 даатгуулагчийн 700.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 2 байгууллагын 966.9 мянган төгрөг, нийт 4048.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүллээ. Сангаас 3 төрлийн тэтгэвэрт нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 2 арилжааны банкаар 136526.5 мянган төгрөг, 2 төрлийн тэтгэмжинд 1638.8 мянган төгрөг, нийт 138165.3 мянган төгрөг тавьж олгосон ба тайлант сард тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 7 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 2 даатгуулагч тэтгэвэрээ тогтоолгосон.

Том малын зүй бусын хорогдол, төл бойжилтын мэдээг нэгтгэн 7 хоног бүр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт мэдээлж байна.

Сумын мал эмнэлэгийн тасгийн мэргэжилтнүүд ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийн дагуу аймгийн Мал эмнэлэгийн газрын даргын баталсан ажлын төлөвлөгөөний хүрээнд суманд зохион байгуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна. Сумын мал эмнэлэгийн тасаг ажлын байртай болох хүсэлтийг уламжилж сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн дэмжүүлж, тогтоол шийдвэрийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт уламжлаад байна.

Багийн Засаг дарга нартай хамтран малын хорогдол, төл бойжилтын мэдээг 7 хоног бүр авч ажиллахаас гадна гадны аймаг сумаас өөрийн нутагт байгаа малын мэдээлэл, өөрийн багаас гадны аймаг сум, багт байгаа, гаднаас худалдаж авсан, худалдаж борлуулсан малын шилжилт хөдөлгөөний мэдээллийг авч нэгтгэн Мал эмнэлэгийн газарт хүргүүллээ.

Тайлант сард Хужирт багийн агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авч, ангийн менежментийг хариуцагч “Хужирт нарийн дав” нөхөрлөлтэй хамтран нийт 1,5 тн хужир 170 боодол өвсийг хужирт агнуурын бүс нутаг 3 цэгт байршууллаа.

Босоо тэнхлэгийн авто замтай Мөст сумыг холбох замын барилгын ажилд БО-ы байцаагч хяналт тавин ажиллаж байна.

Сумын Тэргүүлэгчдийн 02 дугаар тогтоолыг үндэслэн Засаг даргын А/17 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, сумын нийт хашаа, байшинтай иргэн аж ахуй нэгжээс хаягжуулалтын төлбөр хураах ажлыг зохион байгуулж ажлын хэсэг айл өрхүүдээс 4 хашааны 56000 мянган төгрөгийг сумын Засаг даргын Тамгын газрын дансанд төвлөрүүлээ.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард нийт 560 иргэнд үзлэг шинжилгээ хийсэн үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 254 хамруулж, 42 удаагийн дуудлагад явж 47 иргэнийг хэвтүүлэн эмчилж 4 эхийг эсэн мэнд амаржуулсан.

Үенч сум: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өрх толгойлсон, зорилтот бүлгийн эх Г.Долгорсүрэнгийн амьдралд тусламж үзүүлэх “Эвийн хүч-эхчүүдийн сэтгэл” сайн үйлсийн хандивын аяныг амжилттай зохион байгууллаа. Дээрх аянд иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагууд идэвхитэй оролцож сонгосон өрх айлын гэрийг бүрэн тохижуулж мөнгөн хандив гардууллаа.

Мөн энэ үеэр сумын “Манлай”, “Дархан”, “Наран”, “Саран”, “Ачлалт”, “Энэрэлт”, “Халамжит”, “Буянтай”, “Оюунлиг” ээжүүдийг шалгаруулж шагнаж урамшууллаа.

Монгол цэргийн өдөр, зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг угтаж сумын ИТХ, эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “Авьяаслаг эмэгтэйчүүд” дэвжээ тэмцээнд сумын эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүд амжилттай оролцож тэргүүн байр, бизнесийн холбоо 2 дугаар байр, ерөнхий боловсролын сургуулийн МХУЗ-ын багш Д.Соёл-Эрдэнэ ахлагчтай 5 эмэгтэй багш, ажилчид амжилттай оролцож 3 дугаар байр өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангийн сурагчдын дунд аавдаа чин сэтгэлийн үгээ хүргэх “Аавдаа захидал бичээрэй” захидлын уралдаан зарлахад нийт 31 захидал ирсэнээс 10б ангийн сурагч Ч.Буянхишигийн захидал тэргүүн байр, 10а ангийн сурагч Н.Тунгалагийн бичсэн захидал дэд байр, 10б ангийн сурагч А.Жавхлангийн захидал гутгаар байр тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Хүүхдийн “Янзагахан” цэцэрлэг тайлант сард багш ажилчид сарын ажлын төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу багш нар олимпиадын сургалтын хөтөлбөр боловсруулж үзүүлэн тараах материал өдөр тутмын хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэглэгдэхүүнтэй нь чанартай хийж гүйцэтгэж байна. Мөн хүүхэд бүрийн ахицын түвшингийн судалгааг гаргаж хүүхэд нэг бүрийн онцлогт тулгуурлан тоглоомын аргаар цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдүүдийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж эцэг эхчүүдэд танилцуулж мэдээлэв. Хүүхэд нэг бүрт энгийн дадал хэвшил эзэмшүүлэх, заасан дуу шүлэг, хэлбэр дүрс, цифр таниулах ялгуулах өглөөний дасгал хөдөлгөөн зааж сургах зэрэг арга ухаанд сургаж, 3-5 насны хүүхдийг үлгэрийн

тоглолтоор дамжуулан эх хэл, эх орноороо бахархах, өөрийгөө, аав ээж, ах эгчдээ хэрхэн яаж танилцуулах, найз нөхдөө хүндлэх, тэдэнд туслах аргад суралцуулав.

“Номын гэгээ” хөтөлбөрийн төлөвлөгөөг жил, сараар төлөвлөн энэ хүрээнд бүлэг тус бүр том ном, жижиг ном, даавуун ном гараар хийж бүтээл болгон сургалтанд ашиглаж байна. “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийн дунд зураг наамал, даам, шатар, шагайн дугуйлан хичээллүүлж хүүхдийг хөгжүүлж, ардын уламжлалт тоглоом тэмээн тохош, нар самба, оньсон тоглоомууд зааж сургаж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар улирлын хичээл, сургалтын үйл ажиллагаа төлөвлөгөө хуваарийн дагуу хэвийн ажиллаж байна.

Сургалтын менежер, нийгмийн ажилтан, бага ангийн багш зарим багш нар эцэг эхчүүдэд “Хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 60 гаруй эцэг эхчүүд оролцож санал бодлоо солилцов.

Ховд Их сургуулиас зохион байгуулж буй дүрслэх урлаг, зураг зүйн анхдугаар олимпиадад зураг зүйн багш Б. Мөнхбат амжилттай оролцож 2 дугаар байр, 12а ангийн сурагч Б.Давааням 5 дугаар байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Мянгад сум: Сумын нийт төрийн албан хаагчдын дунд “Манлайлал-оролцоо-хөгжил” сэдэвт зөвлөгөөн зохион байгууллаа. Зөвлөгөөнд нийт 150 гаруй алба хаагчид оролцож арга хэмжээнд аймгийн Засаг дарга бусад төрийн байгууллагын зарим удирдлагууд урилгаар оролцож холбогдох салбарын мэдээлэл хийлээ.

Иргэдээс бичгээр 5 өргөдөл, амаар 12 хүсэлт хүлээн авч шийдвэрлэн ажиллалаа.

Ерөнхий боловсролын дунд сургуулийн бага ангийн номын санд нийт 612ш буюу 5626940 төгрөгийн ном хүлээн авч номын санд баяжилт хийлээ.

Халамжийн тэтгэвэрт 12 иргэн, ахмад настан асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийн сунгалт 8, мөн шинээр 1 иргэн бүртгэсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийн сургалтыг 5, жирэмсэн эхийн тэтгэмжид 11, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй 14 эхэд 980000 төгрөг олголоо.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 26125,5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлээ. Үүнээс шимтгэлийн өр 20152,3 мянган төгрөг, сайн дурын даатгалд 38 иргэнээс 3523,2 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд 41 иргэнээс 2450,0 мянган төгрөгийг тус тус орууллаа.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 151825,1 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэвэр авагч 351 хүнд 101997,0 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 38 хүнд 11228,5 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авагч 69 хүнд 37599,6 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 2 хүнд 1272,5 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 3000,0 мянган төгрөгийн санхүүжилт, жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг 5 хүнд 6150,9 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 1 хүнд 69,5 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

Сум орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Баянбулаг багийн нутаг дэвсгэр Алтанхөхий уулын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зүүн хэсэг Хагийн нуур, Дунд хагийн нуур, Бүрдийн нуур, Баянбулаг, Томбогын гол, Сундуйлын гол, рашаан, Сайн өлзийн уул, Шилүүстэй, Майхан улаан уулыг хамарсан 33800га нутаг дэвсгэрийн судалгааг гаргаж аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүллээ.

Дарви сум: Сумын Эрүүл мэндийн төв тайлант сард нийт 490 иргэнд эрүүл мэндийн анхан тусламж үйлчилгээ үзүүлж 57 иргэнийг хэвтүүлэн эмчилж, өдрийн эмчилгээнд 12 хүнийг хамрагдлаа.

Нийгмийн даатгалын сангаас сар бүр өдрийн эмчилгээ, оношлогоо шинжилгээ, гэрээр сувилахуйн зардалд тодорхой төсөв тусгаж энэ хүрээнд өдрийн эмчилгээнд 10, оношилгоо үзлэгт 19 иргэнийг хамруулж 15 иргэнийг гэрээр сувилж эмчиллээ.

Зэрэг сум: Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газарт иргэдээс 4 өргөдөл, 1 хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэнд хариу мэдээлж ажиллав. Иргэний бүртгэлийн 8 төрлийн бүртгэлийг холбогдох хууль журмын дагуу шаардагдах бичиг баримтын бүрдүүлэлт хийж ажиллалаа. Нийт төрөлт 10, гэрлэлт 2, эцэг тогтоолт 1 бүртгэгдэж 9 иргэнд цахим үнэмлэх олгов.

Аймгийн ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөхөөр ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж 2018 онд аймаг болон сумын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн талаар иргэдэд мэдээлэл хүргэж сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажиллав.

Дэлхийн зөн Олон улсын байгууллагын хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурж 20.0\$ малжуулах төслийг орон нутагт хэрэгжүүлэхээр боллоо. Үүнд: нэг өрхөд 10 хургатай хонь, 10 ишигтэй ямаа олгохоор болж 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгууллаа.

Сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Бураа, Гүвээ багийн Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн их эмч, эх баригч бага эмч нар хамтран Бураа, Гүвээ багийн айл өрхүүдийн амьдрал ахуй орчин нөхцөлтэй танилцан аймаг орон нутгийн бодлого шийдвэрийг танилцуулж тэдний санал бодлыг сонсож, 103 өрхийн 188 иргэнд шаардлагатай эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүллээ.

Хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан улсын нөөцөөс 3000ш пресс, 40тн тэжээл авахаар төлөвлөсөн, нутгийн зөвлөлөөс олгож буй 600 уут тэжээлийг хуваарийн дагуу Эхэн, Хөндлөн багийн малчин мал бүхий өрхүүдэд олгоод байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Мартын-8” баярын үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газар, Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, 9 алдартан ээжийг тусгай болзол журмын шалгаруулж, тэдэнд хүндэтгэл үзүүлж алдаршууллаа. Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ой, Монгол цэргийн баярын үйл ажиллагааг Агаарын цэргийн 332 дугаар тусгай салбар ангитай хамтран тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, энэ үеэр Монгол улсын баатар Д.Намнан баатрын хөшөөнд цэцэг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард нийт 350 иргэнд үзлэг оношилгоо хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт 85, диспансерийн хяналтад 86, гэрийн идэвхтэй эргэлт 3, амбулаторийн үзлэгт 174, 2 иргэнд гэрийн дуудлагаар үйлчилж, 15 хүнийг 13А маягтаар дээд шатлалын эмнэлэгт шилжүүллээ. ЭХО оношилогоогоор 22 хүн үзүүлж онош тодрууллаа. Жирэмсний хяналтад 46 жирэмсэн эх байгаагаас шинээр эхний 3 сартайд 3 эх хяналтад ороод байна. 0–2 насны 45 хүүхдийг дархлаажуулалтад хамрууллаа.

Аймгийн ЕБС-ын дунд зохион байгуулагдсан “Эх хэл эрдмийн түлхүүр” монгол хэлний массын олимпиадад 5а, 5б ангийн 60 сурагч хамрагдаж Б.Эрдэнэзаяа багштай 5а анги 2 дугаар байр, Я.Батхишиг багштай 5б анги 3 дугаар байр мөн 4 дүгээр ангийн “Хүн байгаль” хичээлийн массын олимпиадад 68 сурагч хамрагдсанаас Д.Эрдэнэцэцэг багштай 4а анги 1 дүгээр байр, Г.Отгончимэг багштай 4б анги 2 дугаар байр тус тус эзэлэн амжилттай оролцлоо.

Сургуулийн удирдлагаас бага насны хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн энгийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох энгийн дадал төлөвшүүлэхэд анхаарч сумын Эрүүл мэндийн салбар зөвлөл, Ахлах-Б бүлгийн эцэг эхчүүдтэй хамтран “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээн, Ахлах, бэлтгэл бүлгүүдийн дунд амжилттай зохион байгууллаа. Хүүхдийн сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх зорилгоор дунд бүлгийн багш, эцэг эхчүүдээс санаачлан зохион багуулсан “Үртэй хүн жаргалтай” тоглолт арга хэмжээний орлого 560,000 төгрөгөөр 1 ангийг тохижуулахаар ажиллаж байна. Багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлж ажлын байранд сургаж хөгжүүлэх зорилгоор багш тус бүр нэг чиглэлийг сонгон авч мэдээлэл бэлтгэн бусаддаа сургалт зохион байгуулж харилцан туршлага солилцлоо.

Сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг Бод малын суурь өвөлжөө болох “Цагаан аралд” үхсэн малын сэг зэм устгах ажлыг зохион байгуулж нийт 80 гаруй сэг зэмгийг устгалаа. ИБХ-ын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Гүвээ багийн нутаг Хойд шилийн “Бага өл”-ийн зам засварын ажлыг WWF-ын санхүүжилтээр хийж гүйцэтгүүлэхээр Дэлхийн байгаль хамгаалах санд хүргүүлээд байна.